

**ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ
ХУРАЛДААНЫ ТЭМДЭГЛЭЛИЙН АГУУЛГА**
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр, Даваа гараг

Хуралдааны тэмдэглэлийн агуулга	0
Хуралдааны товч тэмдэглэл:	1-2
Хуралдааны дэлгэрэнгүй тэмдэглэл:	3-36
1. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.01.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/	3-36

**Монгол Улсын Их Хурлын
Эдийн засгийн байнгын хорооны
2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр
/Даваа гараг/-ийн хуралдааны товч тэмдэглэл**

Эдийн засгийн байнгын хорооны дарга Р.Сэддорж ирц, хэлэлцэх асуудлын дарааллыг танилцуулж, хуралдааныг даргалав.

Хуралдаанд ирвэл зохих 25 гишүүнээс 13 гишүүн хүрэлцэн ирж, 52.0 хувийн ирцтэйгээр хуралдаан 10 цаг 53 минутад Төрийн ордны “Жанжин Д.Сүхбаатар” танхимд эхлэв.

Чөлөөтэй: М.Бадамсүрэн, Р.Батболд, Х.Баттулга, Э.Батшугар, Л.Соронзонболд, А.Ундраа, Б.Найдалаа, О.Цогтгэрэл, С.Цэнгүүн, М.Энхцэцэг;
Эмнэлгийн чөлөөтэй: Ж.Ганбаатар.

Нэг. “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төсөл /Засгийн газар 2025.01.22-ны өдөр ирүүлсэн, зөвшилцөх/

Хэлэлцэж буй асуудалтай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Хуулийн хэлтсийн дарга Г.Ганбаатар, Ашиглалт, ногоон хөгжлийн хэлтсийн дарга Б.Хулан, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга Х.Итгэлт, мөн газрын шинжээч Г.Дөлгөөн, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, мөн компанийн Дотоод хяналт, эрсдэлийн газрын дарга Э.Түвшинжаргал, Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга О.Цэрэндондог, Хууль, эрх зүйн газрын дарга Э.Уянга нар оролцов.

Хуралдаанд Улсын Их Хурлын Тамгын газрын Хуулийн газрын Зөвлөх үйлчилгээний хэлтсийн зөвлөх С.Дунжидмаа, Байнгын хороодын ажлын албаны Эдийн засгийн байнгын хорооны ажлын албаны ахлах зөвлөх Д.Мягмарцэрэн, референт Б.Ууганцэцэг нар байлцав.

Хэлэлцээрийн төслийн талаарх танилцуулгыг Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан танилцуулав.

Танилцуулгатай холбогдуулан Улсын Их Хурлын гишүүн О.Батнайрамдал, П.Сайнзориг, Д.Энхтүвшин, Ж.Алдаржавхлан, Б.Жаргалан, Н.Батсүмбэрэл, Р.Сэддорж нарын тавьсан асуултад Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Ц.Туваан, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Жавхланбаатар, мөн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга Г.Намчинсүрэн, Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга С.Батболд, Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Л.Мөнхтүшиг, “Эрдэнэс

Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал нар хариулж, тайлбар хийв.

Улсын Их Хурлын гишүүн Ш.Бямбасүрэн, Х.Ганхуяг, Г.Лувсанжамц, О.Батнайрамдал, П.Сайнзориг, Д.Энхтүвшин, М.Мандхай, П.Батчимэг, Б.Жаргалан, Н.Батсүмбэрэл, Б.Мөнхсоёл, Р.Сэддорж нар үг хэлэв.

Р.Сэддорж: “Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн санал хураалт явуулъя.

Зөвшөөрсөн: 11
Татгалзсан: 3
Бүгд: 14
78.6 хувийн саналаар дэмжигдлээ.

Байнгын хорооноос гарах санал, дүгнэлтийг Улсын Их Хурлын гишүүн Н.Батсүмбэрэл Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хорооны хуралдаанд танилцуулахаар тогтов.

Уг асуудлыг 12 цаг 53 минутад хэлэлцэж дуусав.

Байнгын хорооны хуралдаанаар 1 асуудал хэлэлцэв.

Хуралдаан 2 цаг 00 минут үргэлжилж, ирвэл зохих 25 гишүүнээс 14 гишүүн хүрэлцэн ирж, 56.0 хувийн ирцтэйгээр 12 цаг 53 минутад өндөрлөв.

Тэмдэглэлтэй танилцсан:
ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН
ХОРООНЫ ДАРГА

Р.СЭДДОРЖ

Тэмдэглэл хөтөлсөн:
ХУРАЛДААН ЗОХИОН
БАЙГУУЛАХ ХЭЛТСИЙН
ШИНЖЭЭЧ

Э.СУВД-ЭРДЭНЭ

МОНГОЛ УЛСЫН ИХ ХУРАЛ

2025 оны 01 дүгээр сарын 27-ны өдөр, Даваа гараг
Төрийн ордон “Жанжин Д.Сүхбаатар” танхим, 10 цаг 53 минут

ЭДИЙН ЗАСГИЙН БАЙНГЫН ХОРООНЫ ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ ТЭМДЭГЛЭЛ

Р.Сэддорж: Байнгын хорооны эрхэм гишүүдийн энэ өдрийн амгаланг айлтгая. Хуралдаанд оролцож байгаа гишүүдийг танилцуулъя.

Хуралдаанд Улсын Их Хурлын гишүүн Алдаржавхлан, Батнайрамдал Батчимэг, Бямбасүрэн, Ганхуяг, Жаргалан, Лодойсамбуу, Лувсанжамц, Мандхай, Мөнхсоёл, Сайнзориг, Энхтүвшин, Сэддорж нарын гишүүд оролцож байна. Хуралдаанаас Батболд, Бадамсүрэн, Цэнгүүн, Соронзонболд нарын гишүүд чөлөө авсан. Хуралдааны ирцийг танилцуулж дууслаа.

Байнгын хорооны гишүүдийн олонх хүрэлцэн ирж, Байнгын хорооны ирц 52 хувьтай бүрдсэн тул Эдийн засгийн байнгын хорооны 2025 оны 1 дүгээр сарын 27-ны өдрийн хуралдаан нээснийг мэдэгдье.

Байнгын хорооны хуралдаанаар хэлэлцэх асуудлыг танилцуулъя.

Нэг.“Гашуун сухайт-Ганц мод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх /Засгийн газраас 2025 оны 1 дүгээр сарын 22-ны өдөр зөвшилцөхөөр ирүүлсэн, санал, дүгнэлтээ Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд хүргүүлнэ.

Хэлэлцэх асуудал дээр өөр саналтай гишүүд байна уу. Алга байна. Хэлэлцэх асуудалдаа орёе.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөх хэлэлцүүлгийг явуулъя.

Хэлэлцээрийн төслийн талаарх төсөл санаачлагчийн танилцуулгыг Улсын Их Хурлын гишүүн, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Цэвэгдоржийн Туваан танилцуулна. Сайдын микрофоныг нээе.

Ц.Туваан: Байнгын хорооны дарга, эрхэм гишүүд ээ,

Монгол Улсын Засгийн газар, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хооронд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтыг хэрэгжүүлэх хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл батлах тухай Монгол Улсын Их Хурлын 2024 оны 12 дугаар сарын 27-ны өдрийн 58 дугаар тогтоолын хоёрт энэ тогтоолыг хэрэгжүүлэхдээ Засгийн газар

хоорондын хэлэлцээр, ажлын хэсгүүд хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд байгуулах шаардлагатай бол эрх зүйн орчныг бүрдүүлэх зорилгоор хууль тогтоомжийн төсөл санаачлах чиглэлээр ажиллахыг Монгол Улсын Засгийн газарт даалгасугай гэж заасан.

Монгол Улсын Их Хурлын 2024 оны 21 дүгээр тогтоолоор баталсан Монгол Улсын Засгийн газрын 2024-2028 оны үйл ажиллагааны хөтөлбөрт бодлогын үндсэн 4 чиглэлийн хүрээнд 14 мега төслийг хэрэгжүүлэхээр тусгасны 1 дүгээрт Гашуунсухайт-Ганцмод, Ханги-Мандал Шивээхүрэн-Сэхээ хилийн боомтуудын хил дамнасан холболтын төмөр зам, ачаа тээврийн шилжүүлэн ачих терминалыг барина гэж тусгасан.

Тус төслийг хэрэгжүүлснээр нийт экспортын хүчин чадал 40 сая тонноор буюу Гашуунсухайт-Ганцмод боомт 20 сая тонн, Ханги-Мандал боомт 10 сая тонн, Шивээхүрэн-Сэхээ боомт 10 сая тонноор нэмэгдэж, экспортын орлого 2 дахин, төмөр замаар нүүрс тээвэрлэх хүчин чадал 3 дахин, зорчигч болон ачаа тээврийн нэвтрэх хүчин чадал 2 дахин нэмэгдэж, тээврийн хэрэгсэл хилийн боомтоор түргэн шуурхай нэвтрэх, зорчигчдод ая тухтай үйлчлүүлэх боломж бүрдэнэ.

3.3.1.1-д уул уурхайн салбарын түүхий эдийн боловсруулалтын түвшин болон хүнд үйлдвэрлэлийн хүчин чадлыг өсгөж, экспортын орлогыг нэмэгдүүлнэ.

3.3.2.2-т хил дамнасан төмөр замын холболтыг барьж, хилийн боомтуудыг хатуу хучилттай авто замаар холбож, ачаа тээврийн терминалуудыг байгуулж, уул уурхайн бүтээгдэхүүний экспортыг жилд 100 сая тоннд хүргэнэ гэж тус тус заасан.

Уг хил дамнасан төмөр замыг бүтээн байгуулснаар Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, бүс нутгийн хамтын ажиллагаа, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа идэвхжиж, улмаар Шивээхүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүн хатавч боомтуудыг төмөр замаар холбох нөхцөл бүрдэх бөгөөд хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадал 2030 оноос 80 сая тонноор нэмэгдэх стратегийн ач холбогдолтой юм.

Монгол улсын ерөнхий сайдын 4 удаагийн захирамжаар Монгол Улсын Их Хурлын 2023 оны 7 дугаар сарын 7-ны өдрийн, 1955 оны Монгол Хятадын хилийн төмөр замын хэлэлцээр болон Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын ажилтай холбоотой авах зарим арга хэмжээний тухай 68 дугаар тогтоолыг хэрэгжүүлэх ажлыг удирдан зохион байгуулах үүрэг бүхий ажлын хэсгийг байгуулсан бөгөөд ажлын хэсэг Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талтай давхардсан тоогоор 60 орчим удаа уулзалт хэлэлцээр хийсэн.

Монгол Улсын нүүрсний олборлолт, экспортын хэмжээ нэмэгдэж, Үндэсний баялгийн сангийн тухай хуулийн хэрэгжилт эрчимжиж, газрын хэвлийн баялгийн үр өгөөжийг одоо ба ирээдүй үеийн иргэн бүрд тэгш, шударга хүртээх боломжийг бүрдүүлэхийн зэрэгцээ дараах ач холбогдолтой гэж үзэж байна. Үүнд:

Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр замын хэлэлцээр байгуулснаар төмөр замаар экспортлох ачааны хэмжээг жилд 30 сая тонн, түүнээс дээш, Таван толгойн ордын нүүрсний экспортын хэмжээг жилд 70 сая тонн хүртэл өсгөж, нүүрс борлуулалтын орлогыг жилд 1,5 тэрбум доллароор нэмэгдүүлэх.

Монгол, Хятад 2 улсын төрийн тэргүүн нарын 2014 онд баталсан Монгол Улс, Бүгд Найрамдах Хятад Ард Улсын хооронд иж бүрэн стратегийн түншлэлийн харилцаа хөгжүүлэх тухай хамтарсан тунхаглал хэрэгжих нөхцөл бүрдэж, Монгол Улс, БНХАУ хоорондын худалдаа, эдийн засаг, боловсрол, эрүүл мэнд, соёл, хүмүүнлэгийн салбар, олон улс, бүс нутгийн хамтын ажиллагаа, эрдэс баялаг, аж үйлдвэр, дэд бүтцийн салбарын хамтын ажиллагаа эрчимжих, хилийн боомтын нэвтрүүлэх хүчин чадлыг нэмэгдүүлэх.

Эдийн засгийн өсөлт жил бүр 0,8 нэгж хувиар нэмэгдэх, ядуурлын түвшин буурч нэг хүнд ноогдох ДНБ-ийг 10 мянган ам.долларт хүргэх, эдийн засгийн өсөлтийг 6 хувиас дээш түвшинд хадгалах, инфляцыг 5 хувьд барих зэрэг эдийн засгийн болон стратегийн томоохон ач холбогдолтой гэж үзэж байна.

Иймд Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Таван толгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээрийн төслийг Байнгын хороотой зөвшилцөхөөр танилцуулж байна. Хэлэлцэн шийдвэрлэж өгөхийг хүсье. Анхаарал хандуулсанд баярлалаа.

Р.Сэддорж: Ажлын хэсгийг танилцуулъя. Гадаад харилцааны яамнаас. Л.Мөнхтүшиг Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга, Т.Баяржаргал Гадаад харилцааны яамны Хилийн хэлтсийн дарга, Сайд ирээгүй байгаа юм уу. С.Батболд Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Х.Итгэлт Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын дарга, Г.Дөлгөөн Зам, тээврийн яамны Төмөр зам, далайн тээврийн бодлого зохицуулалтын газрын шинжээч. Сайд ирээгүй байна уу. Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд Туваан, С.Жавхланбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Төрийн нарийн бичгийн дарга, Г.Намчинсүрэн Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Эрдэс баялгийн бодлогын газрын дарга, Т.Ганбаатар Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Хуулийн хэлтсийн дарга, Б.Хулан Аж үйлдвэр, эрдэс баялгийн яамны Ашиглалт ногоон хөгжлийн хэлтсийн дарга, “Эрдэнэс Тавантолгой” ХК-ийн гүйцэтгэх захирлын үүрэг гүйцэтгэгч Х.Мөнхжаргал, Э.Түвшинжаргал “Эрдэнэс Тавантолгой” компанийн Дотоод хяналт, эрсдэлийн удирдлагын газрын дарга, О.Цэрэндондог “Эрдэнэс Тавантолгой” компанийн Борлуулалт, маркетинг, тээврийн газрын дарга, Э.Уянга “Эрдэнэс Тавантолгой” компанийн Хууль, эрх зүйн газрын дарга.

Хэлэлцээрийн төслийн талаар асуулт асуух гишүүд нэрсээ өгье. Сайнзориг гишүүнээр тасалъя. Батсүмбэрэл гишүүнийг нэмээрэй. Батнайрамдал гишүүн асуулт асууя.

О.Батнайрамдал: Баярлалаа. Бүгдэд нь өглөөний мэнд хүргэе. Маш чухал хэлэлцээр бас цаг алдалгүй орж ирж байгаад талархалтай хүлээж авч байна. Хэдэн асуулт байгаа юм. Бид нар энэ 2 улсын Засгийн газрын хоорондын хэлэлцээрийн хүрээнд бол Үндсэн чиглэл батлах тухай Улсын Их Хурлын тогтоол гарсан. Энэ тогтоол дээр яг энэхүү хэлэлцээрийг хийхэд баримтална гэсэн нийтдээ 12, 3 зүйл бас туссан байгаа юм.

1 дүгээрт нь үндсэн чиглэл дээр яг 10 дээр бол 1 чухал зүйл орсон байгаа юм л даа. Тэгэхээр ер нь 2 улсын Засгийн газар хоорондоо энэ Гашуунсухайтын

энэхүү төмөр замаа явуулъя гэдэг нь бас зөвхөн Гашуунсухайт-Ганцмод, хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтаас гадна, цаашдаа үндсэн чиглэлийн 10 дээр туссан Монгол, Хятадын хилийн Шивээ хүрэн-Сэхээ, Ханги-Мандал, Бичигт-Зүүн хатавч зэрэг боомтын төмөр замыг ашиглалтад оруулах, үе шаттайгаар эхлүүлэх тохиролцоонд хүрэх гэж маш ойлгомжтой туссан л даа.

Тэгэхээр яг энэ 2 улсын Засгийн газраас байгуулж байгаа энэ түүхэн хэлэлцээрт яг энэ талаар би ерөөсөө олж харсангүй л дээ. Тэгэхээр энэ талаар хоорондоо бас юу гэж ярилцаж, бодсон юм бол. Тэгэхээр ер нь Гашуунсухайтыг бид нар явуулснаараа дараа дараагийн төмөр замын бүтээн байгуулалтууд явах одоо үүд хаалга нь нээгдэж, дараа нь шууд, цаг алдалгүйгээр хамгийн гол нь Гашуунсухайтаа дуусгалаа, дараагийн бүтээн байгуулалтууд бас цаг алдалгүйгээр эхлүүлмээр байгаа юм л даа. Энийг бид нар Улсын Их Хурлын чуулган дээр ч гэсэн олон гишүүд бас дуу хоолойгоо хүргэж байсан. Тэгэхээр болж өгвөл Гашуунсухайт дуусахтай холбоотойгоор бусад төмөр замыг нь бас тэр битгий хэл хамтад нь ашиглалтад оруулж болохгүй юм уу гэсэн асуултыг бол олон гишүүн тавьж байсан байгаа. Тэгэхээр энэ дээр бас Туваан сайд аа хариулт авъя. 1 дүгээрт.

2 дугаарт энэ гэрээн дээр бол 3 цогц байдлаар шийднэ гээд ер нь бол олон жил бас аль аль талаасаа яригдсан л юм байна лээ л дээ. Тэгэхээр үндсэн чиглэл дээр 2 дугаарт бас ингээд туссан байгаа юм. Харилцан уялдаатай цогц байдлаар хамтад нь шийдэх гээд. Гэрээ дээр болохоороо бас нэг ийм асуулт байгаа юм л даа. Гэрээний яг 1 дүгээрт хамгийн гол нэг зүйл нь олборлолтын үйл ажиллагааг эхлүүлэх зорилгоор хүчин чадлыг нэмэгдүүлэх, бүтээн байгуулалтын хамтын ажиллагаа нь Хятадын аж ахуйн нэгжийг арилжааны зарчмаар оролцуулахыг дэмжинэ гээд. Тэгэхээр энэ дээр илүү тайлбар авмаар байна л даа. Цогц байдлаар нь явна. Тэгэхээр бас Хятадын ямар ч аж ахуйн нэгж бас олборлолт дээр оролцох боломжтой гэж энэ гэрээ дээр тусгасан гэж ойлголоо. Тэгэхээр яах вэ, энэ дээр болгоомжилж байгаа нэг зүйл нь яг урьд нь ч гэсэн яг гарч байсан. Тэгэхээр яг энэ тендер олборлолтын тендер гэдэг бол энэ өөрөө тухайн уурхайн хамгийн том өртгийн нэг ... /минут дуусав/

Р.Сэддорж: 1 минут нэмье: Батнайрамдал гишүүн.

О.Батнайрамдал: Тэгэхээр Эрдэнэс Тавантолгой дээр цаашлаад шинэ ордуудыг олборлолтод ингээд үйл ажиллагааг нь оруулахад бол хамгийн том зардлын нэг нь энэ болох юм. Тэгэхээр хамгийн том бизнесүүдийн нэг нь энэ болно гэсэн үг. Тэгэхээр яг энэ тендер болох үеэр ч юм уу, дахиад л яг хэдэн улс төрч хүн болгон Хятадын компани бариад гүйчих вий дээ. Тэгээд буцаад яг тэр улс төржилтөөс болоод олон төсөл гацаж байсан түүх бас давтагдах вий дээ гэсэн айдас энэ дээр харагдаад байна л даа. Тэгэхээр энэ ер нь бол маш нээлттэйгээр л орхигдож байна. Тэгэхээр энийг бас юу гэж ойлгож байгаа юм бол. Үүний хүрээнд бас яг Чайна Энержи хөрөнгө оруулалтын корпорац нь бас яг энэ дээр ямар хамааралтайгаар яг энэ олборлолт дээр орохоор та нар ойлгож энэ дээр тусгаж байгаа юм болоо гэсэн 2 асуулт асууя. Баярлалаа.

Р.Сэддорж: 5 номер. Туваан сайд хариулна.

Ц.Туваан: Батнайрамдал гишүүний асуултад хариулъя. Бид бүхэн энэ сая би бас Байнгын хорооны дарга, гишүүдэд танилцуулга уншиж өгсөн. Дээрээс нь бид

нар Улсын Их Хурлын Тамгын газраас албан хэрэгцээнд гэсэн тамгатайгаар энэ бичиг баримтыг тарааж өгсөн байгаа. Тэгэхээр бас энэ дашрамд гишүүддээ хэлэхэд энийг бас 2 тал нэлээн нууцлаач. Бас албан хэрэгцээндээ хэрэглээч ээ. 2 улсын Засгийн газар хоорондын асуудал, дээрээс нь Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас бол энийг бусад улсуудтай хийх хэлэлцээр дээрээ бол огт задалдаггүй нууцаар явдаг ийм бичиг баримт байгаа гэдгийг хэлсэн.

Тийм учраас манайхан бас энэ дээр анхаараад өгөөрэй гэж хүсэх байна. Үндсэн чиглэл баталсан 12 зүйлтэй баталсны 10 дугаарт нь энэ бусад боомтын асуудлуудыг ярьсан. Тэгэхээр ер нь бол бид нар 1 зүйлийг бас гишүүд маань ойлгож байгаа байх. Юу гэхээр Бүгд Найрамдах Хятад Ард Улсын талаас бас манайх ингээд анхны яриа хэлэлцээнээсээ жоохон буцсан ийм байдалтайгаар анхны хөрөнгө оруулсан төмөр замын асуудлыг холбохгүйгээр дараа дараагийн төмөр замын холболтуудыг 2 улсын хоорондын хэлэлцээрээрээ шахахаар ямар ч байсан эхний ээлжид та нар энэ Гашуунсухайт-Ганцмодоо холбочих. Энэ шийдвэрийг гаргачих. Үүний дараагаар бид нар дараагийн асуудлуудыг авч үзнэ гэдгээ дипломат шугамаар болон шууд байдлаар ерөнхийдөө бид нарт хэлсэн.

Тийм учраас бид нар энэ асуудлаа 1 дүгээрт тавьж явж байгаа. Тэгээд өнөөдрийн энэ асуудал ч гэсэн Гашуунсухайт-Ганцмодны хил холболттой холбоотой асуудлаар явж байгаа. Тэгэхдээ бид нар үндсэн чиглэлийн 10 дугаартаа бусад боомтоо зааж өгсөн. Энэ дээр түрүүн бас та анзаарсан бол миний танилцуулга дотор эхлээд Засгийн газар хоорондын хэлэлцээр, тэгээд ажлын хэсгүүдийн хоорондын албан ёсны хэлэлцээний протокол, аж ахуйн нэгж хоорондын хамтын ажиллагааны гэрээнүүд гээд дахиад 3-ын тоо гарч ирж байгаа юм. Эхлээд хэлэлцээр, дараа нь протокол, дараа нь гэрээ гээд. Энэ 2 дахь буюу нөгөө 2 улсын Засгийн газраас байгуулсан ажлын хэсгийнхэн энэ хэлэлцээртэйгээ цуг протоколд гарын үсэг зурах юм. Энэ протокол дотор яг боомтоор буюу тухайлах юм бол Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээ, Бичигт-Зүүн хатавчийнхаа боомтуудыг оруулчихсан байгаа. Тэгээд ер нь бол бид нар Хятадын талтай маш шуурхай нягт ажиллаж байгаа. Тэгээд энэ хүрээндээ магадгүй энэ 2 сардаа багтаагаад Бүгд Найрамдах Хятад Ард Улсад 2 улсын Засгийн газар хоорондоо энэ хэлэлцээрийг зурах байх. Тэгээд энэ хэлэлцээрийг зурах явцад бас төрийн өндөр дээд түвшинд уулзаж зурж магадгүй. Тэгэх юм бол бид нар тэр уулзалт дээрээ дараагийн төмөр замын хил холболтуудаа шууд залгуулаад ярина гэдэг мэдээллийг бас танд өгье.

2 дугаар асуулт дээр энэ 3-ыг цогцоор гэдгийн 3 дахь буюу уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг асуудал байгаа. Тэгэхээр 2030 оноос жилд 20 сая тонноор нэмэгдүүлээд ирэхээр өнөөдрийн манай Эрдэнэс Тавантолгой компанийн олборлолт одоогийн байдалд олборлож байгаа амнаасаа бол хүчин чадал нь хүрэхгүй. Тэгэхээр бид нар бол зайлшгүй шинэ ам нээх ийм шаардлага байгаа. Тэгээд энэ шинэ амаа нээж олборлолт явуулж байж, энэ жилийн 20 сая тонныг борлуулах гэдэг түвшиндээ хүрэх юм. Тэгэхээр энэ дээр бол бид нар Монгол Улсын хуулийн дагуу энэ дээр тендер зарлан. Тэгээд энэ тендерт бол аж ахуйн нэгжүүд орох нь нээлттэй. Тэгээд бас энэ дээр Батнайрамдал гишүүний болгоомжилж байгааг бас ойлгож байна. Янз бүрийн байдлаар бас энэ гацах вий гээд. Тэгэхээр энэ дээр төмөр замын дэд бүтэц эзэмшиж байгаа компани бас өөрөө орох байх гэж бид нар бас бодож байгаа. Тэгэхээр энэ бол хуулийнхаа дагуу шалгаруулалтаа явуулаад ингээд олборлоно. Энэ олборлолтын зардлыг бол

Монголын тал өөрсдөө гаргаад, өөрөөр хэлбэл операторын зардлыг өөрсдөө гаргаад явахаар урьдчилсан байдлаар харж байгаа.

Р.Сэддорж: Тодруулах уу. Сайнзориг гишүүн асуулт асууна.

П.Сайнзориг: Байнгын хорооны гишүүддээ бас өглөөний мэнд хүргэе. Тэгээд нэлээн чухал асуудал бас орж ирж байна. Уг асуудлыг ч одоо яривал бас л урт түүх. Тэгэхдээ одоо яах вэ, шийдлээ гаргаад явж байгаа нь сайн хэрэг байгаа юм. Тэгээд би энэ хэлэлцээр гэдэг юм уу, уг асуудлын бас нийгэм, эдийн засагт үзүүлэх үр нөлөөг их зөв ойлгуулж, иргэдэд таниулмаар байгаа юм.

Ганцмод-Гашуунсухайтын хил холболтын асуудал холбогдсоноор яг одоо таны танилцуулгад дурдагдаж байгаа, сая Батнайрамдал гишүүний асууж байгаа Ханги-Мандал, Сэхээ, Шивээ хүрэн ч гэдэг юм уу бусад тэр зүүн чиглэлийн боомтууд холбогдох тэр нөхцөл байдал нь Монгол Улсын эдийн засагт ер нь шууд болон шууд бусаар ямар нөлөө үзүүлэх юм. Тээвэр логистикийн төвийн асуудал дээрээ Монгол Улс хэд хэдэн гарцтай болох юм байна. Боомтуудыг төрөлжүүлж хөгжүүлэх ач холбогдлоороо тэр бүс нутагтаа юм уу, бүсчилсэн хөгжлийн хүрээнд ямархуу ач холбогдол үзүүлэх вэ энэ тэр гэдэг зүйлийг эртнээс ойлгож явуулах хэрэгтэй байгаа юм. Тэгэхгүй энэ дээр бол бас ямар нэгэн байдлаар мушгиж унагаадаг, илүү их тийм сонин байдлууд асуудлыг гацааж, удаашруулдаг тийм далдын хүч бол ажиллаж байгаа шүү дээ. Тэгээд энийгээ бид хэд бас хаана хаанаа ойлгуулмаар байна. Энэ 12, 13 жилийн хугацаанд энэ хил холболтын асуудлыг шийдэж чадаагүйгээс эдийн засагт ямар хэмжээний хүндрэл үүсчхээд байгаа юм. Энэ чинь бол гажиг болчихсон шүү дээ. Замын-Үүдээрээ бид хэд бүх юмаа авдаг. Яг үнэндээ хэлэхэд Замын-Үүд дээр чинь нэг томоохон осол болоход Монгол улс тэр чигтээ зогсох гэж байгаа гэдгийг бид хэд бас ойлгох ёстой. Тэгэхээр ер нь энэ асуудлыг бас тэр ач холбогдлоор нь би дэмжиж байгаа юм.

Тэгэхээр Батнайрамдал гишүүний асуулттай бас агуулгын хувьд давхцаад байгаа юм. Тэгэхдээ бас тодруулах нь зөв байх. Энэ дээр нөгөө худалдах, худалдан авах гэрээний хугацаа болон үнийн асуудал байгаа. Ер нь жоохон ойлгомжтой болгохгүй бол дараа нь хэлэлцээрийн явцад хэцүү юм болов уу. Төрийн өмчийн оролцоотой аж ахуйн нэгжүүдийн хооронд байгуулсан Нүүрс худалдах, худалдан авах гэрээний урт хугацааны гэрээ хамгийн сүүлийн үнэ энэ тэр гэж байгаа юм. Хэд хэдэн гэрээ байхыг ч би бас үгүйсгэхгүй байна. Би бас бүрэн мэдээлэлгүй учраас. Яг аль гэрээгээрээ явах гээд байгаа юм. Энэ нь 2, 3 гэрээ байх юм бол Монголд хамгийн ашигтай буюу арай тэр дунджаараа өндөр үнэтэй байгаа тэр гэрээг хэлээд байна уу, эсвэл өөр зүйл хэлээд байна уу гэдэг зүйлийг бас тодорхой байлгах ёстой. Бид хэд юмыг шийдэх ёстой гээд ер нь ийм бүрхэгдүү байдлаар бас заримдаа үлдээж болохгүй гэдэг зүйлийг би хэлэх гээд байгаа юм. Тэгэхээр энэ дээр бас тэр үнийн хувьд бол Монгол Улсад ашигтай байх тэр хамгийн өндөр үнийг сонгох ёстой шүү гэдэг зүйлийг би бас хэлмээр байгаа юм.

2 дугаарт яах вэ энэ сая Батнайрамдал гишүүн ч асууж байна. Хятадын компаниуд бас орж ирэх бүтээн байгуулалтын хувьд. Гарцаа байхгүй орж ирэх л байх. Гэхдээ энэ дээр дотоодын аж ахуйн нэгж байгууллагыг бид нар өмнө нь ч гэсэн удирдамж баталж байхдаа хийж байсан.

Р.Сэддорж: 1 минут нэмж өгье.

П.Сайнзориг: Туслан гүйцэтгэгчээр оруулж ирэх асуудлыг бас тодорхой уг нь протоколын хувьд дурдчихмаар л байгаа юм. Илүү их. Энэ нь ч гэсэн манай зарим хууль тогтоомжийн хувьд манай туслан гүйцэтгэгчдийн авахаас өөр аргагүй байхгүй юу. Олборлолтын хувьд. Тэсэрч дэлбэрэх бодисын эргэлтэд хяналт тавих тухай хуулиасаа эхлээд энэ хуульд тавьсан шаардлагаараа бол бид хэдийн туслан гүйцэтгэгч дээр дотоодын аж ахуйн нэгж, байгууллагуудыг оруулах юм. Тэгэхээр энэ дээр бас нэг тодорхой уг нь нөгөө талдаа ч гэсэн ойлголцлын хүрээнд энд уг нь дурдчихмаар л юм шиг байгаа юм.

Тэгээд сүүлийнх бол яг л одоо Батнайрамдал гишүүнтэй адилхан байна. Энэ хэлэлцээр ядаж тэр оршил хэсэг гэх юм уу, яг энэ удиртгал хэсэг дээр бусад боомтуудыг бас үе шаттайгаар холбоно ч гэдэг юм уу үг, өгүүлбэр уг нь энэ байж байх ёстой юм. Ингэж байж уг нь бас бид хэд ч гэсэн зөвшилцөөд, энийгээ шийдээд явъя гэхэд итгэл төрөх гээд байгаа юм. Протоколын хувьд ингэчихсэн гээд байдаг. Тэгээд л протоколын байтугай бид хэд явсан шүү дээ зарим зүйл дээр. Тэгээд шийдэж чадаагүй юмнууд байгаа. Тэгэхээр эдгээр 3 асуулт дээр бас нэг тодорхой .../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Сайнзориг гишүүний асуултад хариулъя. Бид нар бас анх яригдаж эхэлсэн хугацаа гэвэл 2003 оноос яригдаад, 2009 онд анхны шийдвэрүүд гараад, 2014 онд 2 улсын Ерөнхийлөгчийн хоорондоо зурсан, дээрээс нь 2 улсын иж бүрэн стратегийн түншлэлийн хэлэлцээрт орсон энэ тэр гээд нэлээдгүй энэ цагаас хойш маш хурдан хугацаа алдсан л даа. Тэгэхээр энэ хооронд яах вэ, бид нар бас зарим нэг тооцоог гаргаж үзсэн. Алдагдсан боломжийн өртөг гэж юу байх юм бэ гээд. Бүр дээрээс нь дахиад энийг хийхгүй бол цаашаа алдах боломж ер нь ямар байх юм бэ гээд. Тэгэхээр ер нь бол бид бид нар нүүрсний экспортоос бол 18 орчим тэрбум долларын борлуулалтыг бол алдсан байна гэж ингэж үзэж байгаа. Жилдээ бол бас 4-4,5 тэрбум долларын яг борлуулалтаар ашгаар биш энэ төмөр замуудыг ашиглалтад оруулахгүй бол бас алдах юм байна гэсэн ийм ерөнхий тооцооллууд бол байгаа.

Мэдээж бусад боомтуудаар бол хил холбовол эдийн засгийн үр өгөөжийн талаасаа бол бид нар зөндөө ярьсан. Гашуунсухайт-Ганцмодор бол 20-30 сая тонныг нэмж борлуулна. Дээрээс нь Ханги-Мандал, Шивээхүрэн-Сэхээгээр 10, 10 сая. Энэ дандаа доод хэмжээнүүдийг нь ярьж байгаа юм. Тэгээд дараагаар нь Бичигт-Зүүн хатавч гээд. Тэгэхээр энэ нийтдээ 4 боомтын 3 боомт нь бол 2 талаасаа хоёулангаас нь төмөр замынх нь төмөр замууд нь бол тавигдчихсан. 4 дэх боомт нь бол Бичигт-Зүүн хатавч бол зөвхөн нэг талаасаа төмөр зам нь тавигдчихсан. Төвөгшлийн хувьд бол Гашуунсухайт-Ганцмод хамгийн төвөгтэй. Бусад боомтууд бол газар зүйн байршлын хувьд төвөгшил багатай, маш хурдан холбож болохуйц ийм боомтууд байгаа. Тэгэхээр энийг бид нар яг энэ хэлэлцээртэй хамт ажлын хэсэг зурагдах протокол гэж албан ёсны бичиг баримт байгаа. Энэ дотроо яг боомтоороо заагаад оруулчихсан. Дээрээс нь 2 улсын хооронд эдгээр боомтуудыг холбох хэлэлцээрүүд нь тусдаа байгаа. Одоо бол энэ дээр яг Гашуунсухайт-Ганц мод гээд хамгийн түрүүнд боомт зааж байгаа учраас энэ талаараа нэлээн түлхүү яриад байгаа. Тэгээд бид бүхэн бол Их Хурлаас та бүхний баталж өгсөн үндсэн чиглэлийн дагуу бүх асуудлаа бол яг энэ хэлэлцээрээ зураад л цааш нь шахаад явна гэдгийг бас хэлье.

Нүүрс худалдах, худалдан авах гэрээ дээр бол мэдээж энэ 2 дахь асуудал байгаа. Тэгээд энэ оноос эхлээд энэ хэлэлцээр зурагдаад, 2 компани хооронд нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ хийгдсэн тохиолдолд 2025 оноос эхлээд бид нар одоогийн Эрдэнэс Тавантолгойн ашиглаж байгаа амны хүчин чадлаа нэмэгдүүлэх замаар нөөц бололцоогоо дайчлаад, 5 сая ингээд 2025, 2026 2027 онд 5, 5, 5 сая гээд 15 сая, 2028, 2029 онд 6, 6 сая гээд нийтдээ 27 сая тонныг энэ хугацаандаа өөрөөр хэлбэл шинэ амаа нээх, уурхайн хүчин чадлаа нэмэгдүүлэхээс төмөр замын хил холболтоо эхлэхээс өмнө бол ингээд борлуулж байх юм. Энэ дээр бол ямар нэгэн бартер юм хум бол байхгүй. Шууд тохироод, тохирсон үнийн аргачлалаараа шууд борлуулалт хийнэ. Тэгэхээр яг өнөөдрийн байдлаар бас бид нарт энэ чухал болж ирж байна. Яагаад вэ гэхээр бас нүүрсний үнэ бага зэрэг унасан. Биржийн худалдаан дээр бас янз бүрийн төвөг саадууд гарч ирж байгаа энэ цаг үед бид нарт бол мөнгөн орлогоо бууруулахгүйн тулд борлуулалтаа нэмэгдүүлэх энэ гарцыг нэлээн сайн ажиллуулах ийм шаардлага байгаа.

Үнийн аргачлалын хувьд бол дахиад бид нар энэ гуравласан гэрээн дээрээ эцэслэн шийднэ. Дээрээс нь дотоодын туслан гүйцэтгэгчдийг бол мэдээж бид нар ажиллуулж байж энд ажлын байр, ашиг орлого гэдэг зүйлүүдийг бол ярина. Энэ дээр бол ямар хувь хэмжээгээр дотоодын туслан гүйцэтгэгчид ажиллуулахыг тодорхой хувиар гэрээнүүд дээрээ тусгаж өгч байгаа гэдгийг бас хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: 6 номер нэмж хариулъя.

С.Жавхланбаатар: Сайнзориг гишүүний асуултад нэмж хариулъя. Жавхланбаатар Аж үйлдвэр, Эрдэс баялгийн яам. Яг нөгөө бусад боомтуудын томьёоллыг болохоор бид нар анхны төсөл дээр ярьж байгаад нэр устайгаа явж байсан. Хятадын талын Засгийн газрын талаас энэ бол ерөөсөө Гашуунсухайт-Ганцмод дээрээ төвлөрсөн хэлэлцээр юм. Тийм учраас энэ хэлэлцээрт томьёоллыг нь 5 дугаар хэсэгт бусад гээд хэсэг байгаа. Гишүүд хэрвээ харвал. Бусад хэсгийн эхний өгүүлбэр дээр энэхүү хэлэлцээр хүчин төгөлдөр болсноос хойш талууд хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын бусад төсөл гээд ингээд нөгөө бусад эрчим хүчний төсөл, дэд бүтэц, ер нь томоохон яригдаж байгаа төслүүдээ үргэлжлүүлээд явна шүү гэдэг санаагаа энэ 5 дугаар хэсэгт зааж өгсөн шүү. Энийг бас хараарай гэж хэлье. Баярлалаа.

Р.Сэддорж: Тодруулж асууя. Сайнзориг гишүүн.

П.Сайнзориг: Мэдээлэл өгсөнд баярлалаа. Тэгээд ер нь зүгээр яах вэ ерөнхий энэ ач холбогдлыг өгч болох хэмжээнд олон нийтдээ өгөөрэй. Манай Засгийн газрын гишүүд хэн нэг бүлэг этгээдүүдийн Пи Арт битгий очиж, нэвтрүүлэг хийгээрэй гэж би хүсэж байна. Одоо зарим энэ гацаасан хүмүүс чинь ардын баатар мэт өөрийгөө пи ар-даад эхэллээ. Тийм зүйлд энэ Засгийн газар болон холбогдох бас хариуцлагатай алба хашиж байсан хүмүүс тоглож болохгүй шүү. Тэгээд л ерөөсөө ингээд нэг ийм хуйвалдаан. Сүүлдээ хэн нь энэ эдийн засгийн боломжийг алдуулсныгаа хүртэл марттал ингээд ийм бүлэг заваан үзэл суртлын юмнууд хийгээд байх юм. Энийг бол болиорой гэж би хүсэж байгаа юм. Тэр этгээдүү улс төрийн захиалгаар зарим энэ залуу гишүүдийг бол будаа болгож байх шиг байна. Тэрний нэг нь ч би. Тэгэхдээ тэд нараас нэг их айж хулгаад байх юм алга. Би энэ дээр бүр хатуу хэлчихмээр байгаа юм. Тэгээд тийм юмнуудын гар хөл

болж, тэд нар нь ардын баатар болж тоглодог тийм зүйл бол Монгол Улсад байхгүй шүү. Би энийг бол бүр хариуцлагатай, хатуу хэлмээр байна.

Тэгээд Монгол талаас хариуцах юмнуудаа хиймээр байна. Тэр холбогдох гэж байгаа боомтуудын дэд бүтэц болон зам харгуй гээд бид хэд сая төсвөөсөө бүгдийг нь хасаад хаячихсан шүү дээ.

Р.Сэддорж: Хариулт байна уу. 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ төсөл маань бас тодорхой хэмжээний улс төрийн зөрүүтэй байр сууринуудаас болж гацсан. Тэгэхээр энэ тал дээр бас таны саналыг ойлголоо. Дараагийн зүйлүүд дээр анхааръя. Тэгээд хэвлэл мэдээлэлд бас ярилцлагууд өгч байгаа. Тэгээд тэр дундаас бас ийм асуудалд орсон байх. Дараагийн асуудал дээр анхааръя.

Монголын талын хийх ажлуудаа бол бид нар бас борлуулж байж эдийн засгаа тэлэх, борлуулж байж орлогоо нэмэгдүүлэх, нүүрсний үнийн тодорхой уналт зэргийг нөхөхөд бид нар бол хэмжээгээ нэмэгдүүлж байж эндээс гарна гэдэг ийм тооцоололтой. Сангийн яам, Эдийн засгийн яам ч гэсэн Засгийн газар дээр энэ дээр онцгой анхааруулж байгаа учраас энэ чиглэлд бас ач холбогдол өгч ажиллана гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Өөр нэмж хариулах хүн байгаа юу. Дашцэрэнгийн Энхтүвшин гишүүн асуулт асууна.

Д.Энхтүвшин: Улсын Их Хурал өнгөрсөн оны 12 сард энэ хил дамнасан төмөр замын холболт чухал учраас энийг хэлэлцээрээ хий гэж чиглэл өгсөн. Тэгэхдээ ер нь бол энэ хил холболтын төмөр зам бол чухал ач холбогдолтой гэдэгт ямар ч эргэлзэхгүй байгаа юм. Тэгэхдээ энд нэг хар бууж эхэлж байна. Одоо энэ орж ирсэн гэрээ болохоор нүүрсний дахиад том хулгай явах гээд байгаа юм биш биз дээ гэсэн. Энэ дээр яагаад тэгж харагдаж байна гэхээр энэ орж ирсэн саналууд дээр би Монголын талынхан ажилласан гэж бодож байгаа. Энд бол дандаа Хятадын талын эрх ашгийн үүднээс хандчихсан ийм заалтууд байна. Би жишээ хэлье. Энэ уг нь анх эхэлж гэрээ нь хил холболтын төмөр зам барих гэрээ байснаа одоо энэ хэлэлцээрийн 3.1.1 дээр нь нүүрсний гэрээ энэ уурхайн гэрээ хийхгүй бол төмөр замын чинь энэ ажлыг чинь эхлэхгүй. Урьдач нөхцөл нь ийм байна гэсэн ийм заалт байна. Дээр нь энэ бүр Хятадын сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжих заалт явж байна. Бид нар энэ чинь төмөр зам барих гэж байгаа болохоос Хятадын сэргээгдэх эрчим хүчний экспортыг дэмжих гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Аль талд ажиллаад байгаа юм бэ. Тэгээд дээр нь уг нь бид нар чинь экспорт хийнэ гэдэг чинь аль болохоор хэрэглэгч рүүгээ дөхүүлж өгч байж үнэ цэн бий болгодог байтал чинь аман дээрээ авчирна гэдэг чинь юу гэсэн үг юм бэ. Тээвэрлэлтийн компаниуд Монголчууд уурхай олборлолт бид нар хийж чадаж байна. Тэгээд тээвэрлэлт энэ олон хүмүүс хөрөнгө оруулалт хийчихсэн байна. Ингээд болоод явж байгаа юмыг заавал Хятадын талуудыг оруулж ирэхээр энэ гэрээний чинь 3 цогц гэдэг чинь ер нь бол энэ 3 чинь гурвуулаа байж байж энэ төмөр замын хил холболтын төмөр замын гэрээ биш нүүрсний гэрээ л болчихсон байна л даа.

Тэгэхээр энэ дээр нь энэ төрийн 2 компани гэж байснаа одоо тэр эхний заалт дээр нь байгаа. Чайна Энержи хөрөнгө оруулалтын компанитай хамтарч

ажилладаг Хятадын бүх компаниуд жишээлбэл энд орж ирнэ гэсэн ийм заалтууд. Тэгээд 2 улсын хоорондын хэлэлцээр гэсэн мөртөө энэ нөгөө үнэ тохирч байгаа FCA амны нөхцөлөөр FCA аман дээрээс шууд экспорт хийх боломж байхгүй шүү дээ. Тэгээд энэ нөхцөлийг ингэж тавьж, өөрсдийгөө ингэж доош нь хийж, өөр улсын компаниудыг дэмжиж байгаа ийм заалтууд оруулж ирж байгаад гайхаад байна л даа. Тэгээд энэ чиглэлээр хардаад байгаа юм нь гэхээр яг энэ асуудалд ярихад энэ асуудлын эсрэг байж болох хүмүүс рүү чиглэсэн пи ар ажиллагаанууд явагдсан. Одоо энэ төслийг гацаах гэсэн бүлэглэл байна гэдэг талаар ийм одоо том юмнууд явсан. Тэгэхээр тийм юм байхгүй шүү дээ. Тэгэхээр жишээлбэл миний нэрийг холбож, нэлээн дайрсан. Тэгэхээр би энийг зүгээр тэр үед хардаад байсан юм. Энэ цаана нь нэг том хулгай явах гээд эсрэг байж болох хүмүүсийгээ ингээд байна уу гээд.

Тэгэхээр саяын орж ирж байгаа гэрээ дээр өмнө хил холболтын төмөр зам гэж ярьж байсан бол одоо энэ чинь Хятадын компаниудыг дэмжих асуудал болчихсон. Хятадад нүүрс зарах Хятадын компаниудад 16 жил нүүрс зарах гэсэн ийм асуудал болчихсон байна шүү дээ. Дээр нь бас яг энд өмнө хийж байсан технологиудтай адилхан нууцлалтай оруулж байна. Энэ гэрээний тухай асуудлыг өөр хүн жишээлбэл үзэж харж болохооргүй ийм заалтууд оруулж байна. Тэгэхээр яг л нөгөө урдах үлгэр шигээ л бас л хэсэг бүлэг хүмүүсийн хулгай хийдэг, тэрийгээ хааж нуудаг иймэрхүү асуудал руу орох гээд заалтууд орсон байна л даа. Тэгээд энэ дээр ямаршуу байр суурьтай байгаа юм. Саяын энэ заалтууд яахаараа төмөр замын гэрээ байснаа нүүрс зарахгүй бол уурхайн гэрээ хийхгүй бол энэ төмөр замыг хийхгүй болно. Хятадын компаниудыг нүүрс тээврийн болон Хятадын компаниудыг дэмжих, Хятадын бүр сэргээгдэх эрчим хүчний компаниудыг дэмжих заалтууд болоод явчихдаг юм. Нөгөө талд нь тэр боомтоо дэмжинэ гэсэн яасан. Бусад заалтууд нь байхгүй. Тэр нүүрс сорчлохгүй гэж ярьсан юмнууд нь байхгүй. Тэгэхээр ингэж бас болохгүй байх. Энэ бол .../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 5 Номер Туваан сайд.

Ц.Туваан: Энхтүвшин гишүүний асуултад хариулъя. Тэгээд таны бас болгоомжилж байгаа энэ болгоомжлолыг бол хүлээж авч байна. Бид нар бас гэрээг байгуулах, хэрэгжүүлэх шатан дээр бол маш анхааралтай ажиллана. Янз бүрийн байдлаар алдаа оноо гаргасан бол хариуцлага хүлээхэд бэлэн гэдгээ бас албан ёсоор протоколд хэлье.

Том хулгай гэдэг асуудал ярьж байна. Тэгэхээр энэ дээр бол мэдээж янз бүрийн асуудлууд бол гардаг. Тэгээд бас өмнө нь гарсан асуудлууд дээр хариуцлагаа хүлээгээд явдаг ч хүмүүс байгаа, бас асуудал нь яригдаж байгаа ч зүйлүүд байгаа. Бид бүхний зүгээс бол ямар нэгэн алдаа оноо гаргахгүйгээр улс орныхоо эрх ашгийг 1 дүгээрт тавиад, ард иргэдийнхээ аж амьдралыг дээшлүүлэх, баялгийн санг зузаатгах энэ талд нь бол эхний тэргүүн зорилго тавиад ажиллаж байгаа гэдгийг бас энэ дашрамд хэлье.

3-ыг цогцоор гэж энэ дээр та бүхэн бас анзаарсан байх. Энэ 3 гэрээг анх ерөөсөө нэгийг нь салгаж хийхгүйгээр цуг гэдэг байдлаар энэ зарчмыг 2014 онд 2 улсын Ерөнхийлөгчийн хооронд Ерөнхийлөгч нар оролцож байгуулсан иж бүрэн стратегийн түншлэлийн үеэс хойш одоо 11 дэх жилдээ барьж явж байгаа ийм зарчим. Энэ 3-ыг цогцоор гэдэг дотор нь төмөр замын хил холболт дангаараа биш. Нүүрс худалдах, худалдан авах гэрээ, уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх, төмөр

замын хил холболт гэсэн энэ 3 асуудлыг ер нь салгаж ойлгохгүй гэсэн логигоор өнгөрсөн 11 жилийн хугацаанд ажлын хэсгийн 60 удаагийн хуралдаан дээр бүгд дээр нь энэ зарчмыг бас барьж явж байгаа. Тэгэхээр энэ нэлээн эрт шийдэгдсэн ийм асуудал гэдгийг хэлье.

Дараагийн бид нар энэ Их Хурлаас байгуулсан тогтоолоор өгсөн үндсэн чиглэлээс бол нэг ч зүйл дээр гажаагүй, нэмээгүй, өөрчлөөгүй ингэж орж ирж байгаа. Тэгээд энэ дотор бид нар маш олон амбицтай Монгол Улсын хөгжилд нэмэр болох төслүүдийг нэрээр нь зааж оруулж өгсөн. Бас Хятадын талаас шар шороон шуурга гэдэг зүйлээс бусдыг нь хэлэлцээрт орж болохыг нь хэлэлцээрт нь оруулаад, протоколд орж болохыг нь протоколд нь оруулаад ингээд бүх зүйлийг бас харилцан хүлээн зөвшөөрсөн. Энэ дотор сэргээгдэх эрчим хүчний экспортын асуудал байгаа. Энэ бол Монгол Улсын экспорт. Юу гэхээр Монгол Улсын талаас өргөн уудам нутаг байгалийн нартай, салхитай давуу байдлаа ашиглаж сэргээгдэх эрчим хүчийг үйлдвэрлэж БНХАУ руу экспортолж валютын орлого олох гэдэг энэ логигоор л энэ зүйл гарсан. Энэ ч талаараа бас саяхан манай улсын Ерөнхий сайдын Арабын орнуудад айлчилсан айлчлалын хүрээнд энэ тал дээр хамтран ажиллаж, өмнөд хөрш рүү сэргээгдэх эрчим хүчний экспортыг дэмжих асуудал яригдаж байгаа гэдгийг хэлье.

Өмнө нь Улсын Их Хурлын саяын 58 дугаар тогтоолоос өмнө ноднин 2023 оны 7 сарын 7-ны өдөр Улсын Их Хурлын 68 дугаар тогтоол гэж гарсан. Энэ 68 дугаар тогтоол дотор энэ төмөр замын суурь бүтэц эзэмшигч компанийн гээд ингээд тодорхой нөгөө Чайна Энержи компанитайгаа бас зөвшилцөлгүйгээр ийм заалтаар батлагдсан. Энэ дээр бол нэлээн хүндрэлтэй, төмөр замын төвөгшилтэй бараг 10 давхар байшингийн хэрийн өндөр бетонон гүүрэн дээгүүр 2 төмөр зам зэрэгцэн явах гэдэг ийм төвөгтэй бүтцүүдийг хийх дээр бол туршлагатай компанийг олж, сонгож оруулна гэдэг ийм логигоор бас нөгөө тал хандаж байгаа гэдгийг хэлье.

Тэгээд нүүрс бол бид нар борлуулна. Тэгээд энэ борлуулалт бол бид нарт одоо яг амин чухал, нэн шаардлагатай байгаа. Ялангуяа бас нүүрсний үнэ жоохон багасчихсан байгаа энэ үед бол борлуулалтаа нэмэгдүүлж, орлогоо дутагдуулахгүй байх гэдэг логик явж байгаа.

Р.Сэддорж: Энхтүвшин гишүүн тодруулъя.

Д.Энхтүвшин: Бас 1 мэдээллийг илүү дахиад яачихмаар байна. Бид нар одоо энэ төмөр замын чинь Монгол талынхаа монголчууд нь бид нар татвар төлөгчдийнхөө мөнгөөр, Эрдэнэс Тавантолгой өөрсдийнхөө мөнгөө гаргаад барьж байгаа. Хятад тал нь өөрсдийнхөө мөнгөө гаргаж байна шүү дээ. Дээр нь энэ 16 жил нүүрс өгч байгааг яагаад энэ хямдралтай, хөнгөлөлттэй нөхцөлөөр бусдад энэ боломж олгож байгаа гэдгийг дахиад нэг тайлбар авчихмаар байна. Энийг ерөөсөө одоо болтол сайн ойлгохгүй байгаад байгаа юм.

Тэгээд сайд бас худлаа яриад байна л даа. Энэ гэрээ дээр чинь бид нарт өгсөн материал эсвэл өөр юм тарааж өгсөн юм уу. Сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжих. Манайд чинь ямар юмаараа тоног төхөөрөмж үйлдвэрлэж, Хятадад сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж нийлүүлэх юм бэ. Ийм асуудал Улсын Их Хурал дээр тогтоол ярихад ийм асуудал Хятадын сэргээгдэх эрчим хүчний компаниудын тоног төхөөрөмжийн экспортыг дэмжинэ

гэдэг асуудал юу ч яриагүй. Тэгээд энэ дээр чинь тэгээд хар дээр цагаанаар бичсэн юмыг чинь л асууж байна шүү дээ.

Р.Сэддорж: Импорт гэсэн үү. Экспорт гэсэн үү. 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энийг 5 дугаар зүйл заалтад байх шиг байна. Энэ дээр сэргээгдэх эрчим хүчний экспорт гэж энэ тоног төхөөрөмж гэдгийг нь би бас тодруулаад энэ хуралдаан дуусахаас өмнө танд бас хэлье. Энэ дээр бол тэндээс сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмж манай улс импортлох талаар бол ямар нэгэн Их Хурлын тогтоол дээр байхгүй. Бид бүхэн харин түрүүний миний хэлсэн давуу талуудаа ашиглаж, сэргээгдэх эрчим хүч үйлдвэрлээд, БНХАУ руу экспортлох гэдэг ийм асуудлыг ойлгож, ярьж байгаа гэдгийг хэлье.

Энэ дээр манай Эрдэнэс Тавантолгой компани Бүгд Найрамдах Хятад Ард Улсын төрийн өмчит болон хувийн 4 компанид урт хугацаанд нүүрс худалдах, худалдан авах гэрээний дагуу экспорт хийж байгаа. Тэгэхээр энэ бол хөнгөлөлттэй гэж хэлэхээсээ илүүтэйгээр урт хугацаанд явж байгаа ийм худалдаа. Энэ бол бид нар борлуулсан дүнгээрээ шууд гэрээнийхээ дагуу төлбөрөө авна. Олон улсад бол энэ нүүрс бол биржийн бүтээгдэхүүн биш, нурмага ачаа гээд биржийн бус бүтээгдэхүүнд ордог. Жишээлбэл биржүүд дээр тухайн нүүрсийг экспортолж байгаа компаниудын хувьцааны арилжаа л гэж байдаг болохоос биш нүүрс тэдэн доллароор биржээр арилжаалагддаг гэдэг энэ зүйл бол байхгүй. Манайд бол тодорхой нөхцөл буюу Уул уурхайн биржийн тухай хууль хэрэгжээд тодорхой алдааг бас засах ийм зорилготой ийм хууль баталсан. Тэгээд өнөөдөр бол яг үнэндээ бас биржийн арилжаа маань арилжсан нүүрсээ хүргэж өгөх гэдэг асуудал, дээрээс нь тэнд эцсийн томоохон хэрэглэгчид бас энэ биржийн арилжаанд оролцох гэдэг утгаараа 2 төрлийн бас хүндрэлүүдтэй нүүр тулаад явж байгаа гэдгийг бас энд хэлье.

Р.Сэддорж: Би бас асуучихъя. Энэ Гашуунсухайтын боомт огт усгүй. Одоо шавар зуурах ч ус байхгүй. Нөгөө Хятадын тусламжаар баригдсан сайхан боомтын барилга нолийн ус нь ч байхгүй. 60км-ээс ус зөөж байгаа. Тэгэхээр та бүхэн Гадаад хэргийн яам байна. Энэ төрийн өмчийн компаниудтай 2 улсын Засгийн газар яаж байгаа юм чинь ядаж Гашуунсухайтын боомтоо устай болгоно биз дээ. Ингэж байж наад барилгын том бүтээн байгуулалтын ажлууд хийгдэх байх гэж бодож байна.

Дээрээс нь орон нутгийн аж ахуйн нэгжүүдийг, компаниудыг дэмжих, тогтоолд оруулсан ажлын байрыг нэмэгдүүлнэ. Хэдэн ажлын байр яг энэ бүтээн байгуулалтын явцад байх вэ. Дээрээс нь хэдэн байнгын ажлын байр нэмэгдэх вэ.

Мөн Зам, тээврийн яам байна. Нөгөө хос зам яасан бэ. Гашуунсухайтын хос зам, нөгөө концессын зам юу болсон бэ. Энэ зам баригдаагүйгээс ямар олон аваар осол гарч хүний алтан амь эрсэдсэн, тэгээд энийг ерөөсөө ингээд анхаарахгүй ингээд орхиж байна. Тэгээд тээвэрчид авто тээвэр хил холболт ашиглалтад орсноор хил холболтын явцад авто тээврийн тээвэрчдийн тээврийн компаниудын үйл ажиллагаанд ямар нөлөө үзүүлэх вэ. 5 номер. Туваан сайд.

Ц.Туваан: Зам, тээврийн яам сүүлийн Байнгын хорооны даргын асуултад хариулна биз. Усны асуудлыг Эрдэнэс Тавантолгой компаниас хариулчихъя. Энэ дээр бол бид нар түрүүн хэлсэн. Энэ 3 давхар юм явж байгаа. Хэлэлцээр, түүний

дараагаар түүнтэй цуг зурагдах ажлын хэсэг хоорондын протокол. Энэ албан ёсны баримт бичигт орж явна. 3 дугаарт нь 2 төрийн өмчит компанийн хоорондын гэрээний асуудал. 3-ыг цогцоор гэрээний асуудал. Энэ гэрээнүүд ингээд шат дараалаад зурагдаад явахдаа бид нар бас энэ гэрээнүүд дээр тохироод, энэ үндсэн чиг, хэлэлцээрээ баримтлаад цаашдын гэрээнүүдээ хийгээд явна. Энэ дээр бол яг энэ төмөр замын хил холболтын бүтээн байгуулалтад түр ажлын байраар 1 мянга орчим ажилчин ажиллахаар, тэгээд цаашдаа ашиглалтад орсноор 400 ажлын байр тогтмол нэмэгдэхээр ийм тооцоололтой явж байгаа.

Р.Сэддорж: 4 номер.

С.Батболд: Сэддорж гишүүний асуултад хариулъя. Зам, тээврийн яамны Төрийн нарийн бичгийн дарга Батболд. Энэ хил холболтын 2 зам явж байгаа. 1 нь Тавантолгойгоос Хангийн боомт хүртэлх замын ажил дууссан. Манайд хүлээлгэж өгье гэдэг асуудал бол тавьж байгаа. Хараахан бид нар бас шаардлага хангаагүй байгаад байгаа учраас одоогоор хүлээж аваагүй байна. Нөгөөдөх нь Гашуунсухайт чиглэл рүү явж байгаа авто замын асуудал бол удаашралтай байгаа. Энэ 2 зам, хоёулаа концессын гэрээгээр Эдийн засаг, хөгжлийн яам үндсэн хариуцагчаар явж байгаа. Бид бол энэ Гашуунсухайт хүртэлх энэ замын гүйцэтгэгч бол ажлаа хийж чадахгүй нь. Энэ гэрээг цуцалъя гэдэг асуудал тавьж байгаа. Энэ ажил бол удаашралтай байна.

2 дахь асуудал нь төмөр замын барилгын ажил 2 жилийн хугацаанд бид барихаар төлөвлөж байгаа. Энэ хугацаанд авто тээвэрчдийн ажлын байр хөндөгдөх нь гайгүй болов уу гэж бодож.../минут дуусав/

Р.Сэддорж: Гүйцээж хариулах уу. 4 номер.

С.Батболд: Цаашдаа төмөр зам баригдаад ирэхээр мэдээж авто замаар зөөж байгаа энэ экспорт бол багасна. Тийм учраас энд ажиллаж байгаа өнөөдөр 15 мянга орчим тээвэрчид байгааг бид нар өөр ажлын байр луу шилжүүлэх, ялангуяа тэр Хангийн боомт руу тээвэрлэх, бусад хил холболтын авто замын ажлууд манай дээр бас эхэлж байгаа. Жишээ нь Баянхонгороос Шинэжинст, Ховдоос ахиад Байтагийн боомт гэх мэтчилэн энэ замуудын ажил руу шилжих боломжтой гэж үзэж байгаа юм.

Р.Сэддорж: 7 номер.

Х.Мөнхжаргал: Сэддорж даргын асуултад хариулъя. Усны хувьд тантай санал нэг байгааг Гашуунсухайт боомт дээр ажиллаж байгаа манай Эрдэнэс Тавантолгой компанийн Эрдэнэс нэгдсэн терминал цогцолбор дээр хүртэл усны асуудал одоо хүртэл яригдаж байгаа. Бид бол тэнд бараг 30км-ээс өөрсдөө усаа зөөж одоо хүртэл ажиллаж байгаа. Тэгээд цаашдаа бол компанийн зүгээс усны шинэ нөөц эх үүсвэр гаргах, хайгуул хийх тийм зорилтыг тавиад ажиллаж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Урд талын нөгөө Ганцмод боомт бол бас 100 гаруй километрээс усаа татсан юм байна лээ. Тэгэхээр тэнд бол ус ирчихсэн байгаа юм байна лээ. Тэгээд энэ төрийн өмчийн компаниуд 2 улсын Засгийн газар хоорондоо хамтарч ажиллаж байгаа энэ үед бол хэдхэн километр хүрэхгүй газрын наана цааныг л бид

нар ярьж байгаа шүү дээ. Тийм учраас энэ дээр бас та бүхэн бодолцоорой гэдгийг хэлье. Одоо Жуковын Алдаржавхлан гишүүн асуулт асууна.

Ж.Алдаржавхлан: Энэ өдрийн мэнд хүргэе. 1 дүгээрт энэ хэлэлцээр маань зөвхөн төмөр замын хэлэлцээр биш болчихсон тийм ээ. Бүгдээрээ ойлгож байгаа. Одоо иргэд маань бас сонсож байгаа. Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, дээр нь нүүрсний худалдаа, Таван толгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай гэрээ гэсэн бүр тийм том гэрээ байгаа. Энийг бас ийм болсон гэдгийг нь бас хүмүүс сонсож байгаа байх гэж би бодож байна. Үүнтэй холбогдуулаад 2, 3 асуулт байна.

1 дүгээрт энэ хэлэлцээр хийхдээ манай Монголд чинь нэг ийм зовлон байдаг шүү дээ. Нүүрс сайхан гараад, валютын орлого нэмэгдээд явж байтал гэнэт Хятадын тал маань нүүрс авахаа больчихдог. Тэгээд түүнтэй холбогдуулаад валютын ханш савладаг, эдийн засагт хор нөлөө учирдаг тийм ээ. Тэгэхээр энэ тогтвортой байдлынхаа гэрээнийхээ хэлэлцээртээ тогтвортой байлгах асуудлыг тусгаж өгөх талаар ажиллаж байгаа юу. 1 өдөр бид нар болилоо. Танайд ийм асуудал үүссэн учраас бид нар нүүрс авахаа болилоо гээд Хятадын тал шууд шийдвэр гаргадаг. Тэр нь Монголын эдийн засагт шууд нөлөөлдөг. Монгол хүмүүсийн аж амьдралд шууд нөлөөлдөг. Энийгээ та хэд нэгэнт хэлэлцээр хийх гэж байгаа юм чинь тогтвортой байдлынхаа асуудлыг оруулж өгөөч гэж.

2 дугаарт нь энэ Эрдэнэс Тавантолгой гээд компани энэ ажлыг хариуцах юм байна шүү дээ цаашдаа. Тэгээд өмнө Эрдэнэс Тавантолгой компанийн захирлууд чинь Монголын хамгийн баян хүн болтлоо баяжиж, Монголын хамгийн их асуудлыг үүсгэж байсан хүмүүс. Одоо тэгээд бүгдээрээ хуулийн хариуцлага хүлээчихсэн явж байгаа. Яг энэ замаар орохгүй гэсэн баталгаа байгаа юу. Одоо энэ Эрдэнэс Тавантолгой захирлууд гэдэг хэсэг хүмүүс сууж байна. Энэ ямар учиртай хэзээ томилогдсон хүмүүс юм бэ. Тэгээд энэ хариуцлагын асуудлыг Туваан сайд хяналт энэ тэрээ сайн тавьж чадна биз дээ. Энийгээ бас Их Хурлын Байнгын хороо дээр албан ёсоор хэлээрэй. Яагаад гэвэл энэ хэлэлцээр чинь хийгдээд бүтээн байгуулалт өрнөөд нүүрс энэ тэр чинь орж гараад эхлэх юм бол наад Тавантолгойн асуудлууд чинь нэлээн хурцаар яригдана. Тэгээд өмнөх хүмүүсийн алдааг давтахгүй байх чиглэлээр ер нь та хэд бодож төлөвлөж байгаа юм байна уу. Эсвэл гаднын өндөр боловсролтой мэргэжлүүдийг авчирч болдоггүй юм уу. Заавал хүмүүсийн гар хөлүүдийг аваачиж тавих шаардлага байна уу, үгүй юү гэдэг дээр бас нэг хариулт өгчих. Би сайн мэдэхгүй шүү. Уучлаарай. Энэ Тавантолгойн захирлуудыг би танихгүй, мэдэхгүй учраас л асууж байгаа юм. Өмнө нь ийм асуудлууд үүсээд байсан учраас асууж байгаа юм.

3 дугаарт нүүрс сорчилж авдаг гэсэн асуудал яригддаг. Энийг хэлэлцээр дээр оруулж өгөөч. Монголын нүүрсийг чанартай хэсгийг нь авч ачаад, чанаргүйг нь үлдээчихдэг гэж байгаа юм. Тэгээд чанаргүй хэсгийг нь яах яах юм бэ. Тэгэхээр энэ сорчлохгүй гэдэг юмаа та хэд хэлэлцээртээ оруулж өгнө биз дээ. Өмнө чуулган дээр оруулна гэж хэлсэн шүү Туваан сайд аа. Энэ хэвээрээ биз дээ. Энийгээ хэлэлцээртээ оруулж байгаа эсэх. Энэ 3-ыг хариулж өгөөч ээ гэсэн асуулт байна.

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд хариулна.

Ц.Туваан: Алдаржавхлан гишүүний асуултад хариулъя. Хэлэлцээр 3-ыг цогцоор гээд энэ 3 хэлэлцээр маань цогцоороо ингээд зэрэг зурагдаад явна. Энэ

дээр бол нүүрсний борлуулалт дээр бол бид нар нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ хийгдэнэ. Энэ дээр бол дээд хэмжээгээ жилдээ эхний 3 жил 5, дараагийн 2 жилд 6, дараагийн 11 жил 20 сая тонн гээд ингээд зааж өгч байгаа. Тэгээд энэ дээр бол бид нар тогтвортой борлуулах заалтыг гэрээндээ оруулж өгч байгаа. Таны бас сануулснаар энэ заалтаа бас илүү чамбайруулж орно гэдгийг танд хэлье.

Эрдэнэс Тавантолгой компанийн удирдлагууд өнөөдөр бас Мөнхжаргал захирал Эрдэнэс Тавантолгой компанийн үүрэг гүйцэтгэгчээр ажиллаж байгаа. Эрдэнэс Тавантолгой компани маань “хувьцаа эзэмшигч нь бол Эрдэнэс Монгол” нэгдлийн бүрэлдэхүүнд ордог. “Эрдэнэс Монгол” нэгдлийн хувьцаа бол ЗГХЭГ-т байдаг. Аж үйлдвэр, эрдэс баялгийн яаманд бол энэ уул уурхайн компани учраас бодлогын болон аудитын дүгнэлт зэргээрээ бол холбогдож ажилладаг. Тэгэхээр энэ дээр бол ЗГХЭГ-тай хамтран хяналт хариуцлагыг бас ингээд шахаад тооцоод явна. Мөн та бас мэдээлэлтэй байгаа байх. Засгийн газар дээр шийдвэр гаргаад, ТӨБЗГ дээр шийдвэр гараад, төрийн өмчит компаниуд дээр хяналт хариуцсан менежер, бүтээмж хариуцсан менежерүүдийг бас шинээр яг саяын таны хэлсэн агуулгаар хяналтыг сайжруулах чиглэлээр бас тавигдаад, эхний хүмүүс нь бас ажилдаа ороод явж байгаа.

Мөн Засгийн газар дээр бас нэг санал орж ирээд батлагдаад, судалгааныхаа түвшинд явж байгаа зүйл бол энэ томоохон хэмжээний компаниудыг ялангуяа Эрдэнэт төрийн өмчит үйлдвэрийн газар, Эрдэнэс Тавантолгой компани дээр гаднын менежментийн багийг ажиллуулах судалгаанууд бол хийгдээд, Эрдэнэс Тавантолгой компани дээр бол гаднын менежментийн багийн байж болох хувилбаруудыг танилцуулаад, үргэлжлүүлэн судлагдаж байгаа. Нэг хувилбар гэхэд бол гаднын менежментийн баг, гаднын болон дотоодын менежментийн хамтарсан баг, энэ дотроо гадных нь 5 хүнтэй, дотоодынх нь 2 хүнтэй ийм 7 хүний удирдлагын багтай байхаар ийм эхний танилцуулга бас хийгдээд явж байгаа гэдгийг хэлье. Тэгэхээр энэ чиглэл рүү бас ажиллагаанууд явагдаж байгаа.

Нүүрс дээр бол манай нүүрс маань өөрөө ингээд жишээлбэл одоо ашиглаж байгаа Эрдэнэс Тавантолгой ам бол нийтдээ 13 орчим давхаргаас бүрдэж байгаа. Энэ давхаргын тодорхой 2 давхаргаас коксжих нүүрс буюу тэр өндөр үнэтэй нүүрс, бусад давхаргаас бол 3-ны 1-ийн коксжих, эрчим хүчний нүүрсүүд гардаг. Тэгэхээр энэ нүүрснүүдийг бол бид нар сорчлохгүй, тус тусад нь үнэ тохироод, тодорхой хувиудыг барих замаар борлуулалтаа хийгээд явна. Тэгээд энэ дээр бол коксжих нүүрс дээр 55, 3-ны 1-ийг коксжих дээр 35, эрчим хүчний нүүрс дээр 10 хувь гэсэн энэ харьцааг барьж явахаар эхний байдлаар гэрээнүүдээ тусгаад явж байгаа. Үнүүд нь бол ондоо байна гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Алдаржавхлан гишүүн тодруулж асууна.

Ж.Алдаржавхлан: Их Хурлын чуулган дээр бас нэг зүйлийг Дэлгэрсайхан сайд протоколд тэмдэглүүлж хэлсэн. Тэрийг би бас та бүгдээс шаардана. Тэр биржийн үнийг 20 сая тонноос дээш явахад хэрэглэнэ гэсэн тэрийг хэлэлцээр дээр заавал тусгаж өгөөрэй. Одоо энэ чинь бол хөнгөлөлттэй үнээр явах гээд байгаа шүү дээ. Тэгэхээр хөнгөлөлтөө аль болох багасгаж, тэгээд хөнгөлөлтийг нь дээд хязгаарт хүрмэгц биржийн үнэ рүү худалдаалах ажлаа та хэд хариуцна гэдгийг сануулъя.

2 дугаарт тэр Тавантолгойн асуудлыг яриад байгаа нь энэ та нар хяналтын менежер гэж аваачиж тавьчихаад тэр чинь очоод хамтдаа хуйвалдчихна. Тэгээд болж өгвөл бас гаднын өндөр чадварлаг улсуудыг авчруулж ажиллуулах нь зөв байх гэж бодож байна. Өмнөх 2 захирлууд нь хоёулаа асуудалдаа орчихсон учраас итгэхгүй болчихоод байна шүү дээ. Ард түмэн чинь Эрдэнэс Тавантолгойн хариуцсан хүмүүст. Тэгэхлээр болж өгвөл одоо гаднын бас өндөр чадварлаг менежерүүд авчраад, тодорхой хугацаагаар ажиллуулахгүй бол аваачиж тавьсан тэр хяналтын менежерүүд чинь найзлаад, тэгээд хамтдаа хуйвалдаад явчхаж магадгүй ээ. Тийм .../минут дуусав/

Р.Сэддорж: 5 номер. Туваан сайд.

Ц.Туваан: Энэ борлуулах нүүрснүүдийн хэмжээ бол эхний 3 жилд 5 сая хүрээд, түүнээс дээш гарах юм бол таны хэлсэн үнэ рүү орно. 6 сая дээр мөн адил 20 сая дээр мөн адил. Энэ хүртэл хэмжээнүүдийн үнийн асуудал гэж ойлгож болно. Тэр удирдлагуудын асуудал дээр бол энэ ажил нэлээн эрчимтэй ЗГХЭГ-ын дарга болон Ерөнхий сайд нар бас энэ асуудлыг нэлээн үр дүнтэй болгох, үр ашигтай болгох, хариуцлагатай болгох талаас нь бол шахаж ажиллаж байгаа.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн. 7 номер нэмж хариулах юм уу. 7 номер нэмээд хариулчих.

Х.Мөнхжаргал: Гишүүний асуултад нэмж хариулъя. Эрдэнэс Тавантолгой компанийн одоогийн удирдлагын багийг асуусан. Одоогийн удирдлагын яг энэ төсөл дээр ажиллаж байгаа баг бол Монгол Улсын Засгийн газраас 2022 оны 10 сард тогтоосон онцгой дэглэмийн үед бүрэн эрхт төлөөлөгчтэй хамт ирж томилогдсон баг ажиллаж байгаа гэдгийг бас дурдах гэсэн юм.

Мөн чанаргүй байгаа нүүрсээ яах вэ гээд түрүүн асуусан. Компани дээр олборлогдож байгаа нүүрсийг бол бид нар аль болох сорчилж олборлохгүй, сорчилж борлуулахгүй бодлого баримталж байгаа. Чанар муутай хэсгээ бид нар угааж баяжуулна. Угааж баяжуулаад угаасан нүүрс зарахаар манай үйлдвэр ашиг ашиглалтад ороод эхнээсээ авхуулаад комисс ажиллаад явж байгаа. Баярлалаа.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн асуулт асууна.

Б.Жаргалан: Баярлалаа. Анх Засгийн газраас Улсын Их Хуралд чиглэл өгөх тогтоол оруулж ирэхэд би хэлж байсан. Ер нь бол энэ баримт бичгүүд дээрээ дандаа Хятадын талын үг үсгүүд, Хятадын талын ашиг сонирхлыг илтгэхүйц байдлаар энэ томьёоллууд яваад байна. Энэ дээрээ анхаараач гэдэг.

Тэгээд энэ 3-ыг цогцоор гээд энэ томьёолол бол угаасаа Хятадын талаас орж ирсэн томьёолол. Тэгээд энийг бол яг хэлэлцээрийн хүрээнд бүр ингээд албажуулчихаж байгаа юм байна. Тэгээд яг энэ хэлэлцээртэй холбоотой тодорхой асуултууд бас байна л даа.

Хэлэлцээрийн хэрэгжилтийг хариуцах байгууллагууд гэдэг дээр Монголын талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, Хятадын талаас Үндэсний хөгжил шинэчлэлийн хороо гээд байна. Үндэсний хөгжил шинэчлэлийн хороотой бол манай талаас бол Эдийн засаг, хөгжлийн яам бол дүйцэхүйц чиг үүрэгтэй л байх. Энэ 2 байгууллага яагаад хамаарах болсон бэ гэдэг нэг асуулт.

2 дугаарт болохоор яг хэрэгжүүлэгч гэдэг утгаараа Эрдэнэс Тавантолгой ХК болон түүний хамаарал бүхий хуулийн этгээдүүд гэж байгаа юм. Хамаарал бүхий хэчнээн хуулийн этгээд байгаа вэ. Нөгөө тал дээр бас ялгаа байхгүй Чайна Энержигийн хамаарал бүхий хуулийн этгээдүүд гээд. Мэдээж хэрэг нүүрс худалдах, худалдан авах урт хугацааны гэрээ гэдэг дээр бол анх тогтоол батлагдах болохоор 2 асуудал бо Их Хурал дээр нэлээн яригдаж байсан.

1 дүгээрт бол мэдээж хэрэг хэмжээ. Тэгээд тогтоол дээр бол хэмжээг бол нарийвчлан заасан. Хятадын тал бас тийм шаардлага тавьж байна гэсэн үндэслэл гаргаж байсан. Гэтэл энэ удаад бол хэмжээ заагаагүй байна. Одоо нөгөө 5, 5 жил бүр дараа нь 20 сая энэ тэр гэдэг хэмжээ. Тэгээд энэ хэмжээ яагаад заагдаагүй вэ.

Үнэ дээр болохоор бас анх ярьж байснаас бага зэрэг арай өөр томъёолол орж ирж байна. Анх болохоор урт хугацааны гэрээтэй бусад Чалкогийн гэрээ шиг гэрээтэй дүйцэхүйц хэмжээний томъёо байна гэж ярьж байсан бол энэ удаад болохоор анхны үнэ гэдэг ойлголт оруулж ирж байгаа юм байна. Энэ анхны үнэ дээр хамтран сонгож авсан улирлын индексийн тохируулга гээд. Энэ үнэ тэгээд ер нь яг хэчнээн хувийн хөнгөлөлттэй болж тарах гэж байна.

3 дээр олборлолтын тухайд энд бол ерөөсөө огт өмнө нь дурдагдаагүй нэг асуудал ороод ирчихсэн байгаад байгаа шүү. Туваан сайд аа. Яагаад вэ гэхээр өмнө нь энэ нь болохоор энэ олборлолт дээр уурхайн уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэдэг дээр бол тендер зарлаад явна л гээд байгаа шүү дээ манай хуулиар. Гэтэл энэ хэлэлцээр дээр чинь болохоор нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх бүтээн байгуулалтын хамтын ажиллагаанд Хятадын аж ахуйн нэгжийг арилжааны зарчмаар оролцохыг дэмжиж, таатай нөхцөл бүрдүүлнэ гээд. Энэ үг, үсэг бол нөгөө тогтоолд бол огт байхгүй шүү. Тэгэхээр би бол энийг та хэд дараа нь энэ хэлэлцээртээ гарын үсэг зурахаас өмнө бол энэ үг, өгүүлбэрийг бол авч хаях нь зөв гэж харж байна.

Тэгээд дахиад бас нэг зүйл нь болохоороо энэ 5 дугаар .../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт. 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Жаргалан гишүүний асуултад хариулъя. Хэрэгжилтийг хариуцах дээр бол Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, салбарын яам гэдэг утгаараа. Хөгжил шинэтгэлийн хороо Хятадын талаас. Хөгжил шинэтгэлийн хороо бол хуучнаар бол Төлөвлөгөөний комисс шиг. Дээрээс нь Хятаддаа бол яамдын яам гэж явдаг. Засгийн газрынхаа бүрэлдэхүүнд ороод явдаг. Тэгээд энэ дээр бол манай улсын Засгийн газрын хувьд бол Засгийн газар дээрээс 2 улсын Засгийн газар хоорондын комисс, түүн дээр нь доод талд нь эрчим хүч, дэд бүтэц, Эрдэс баялгийн зөвлөл гэж зөвлөл байгаа. Тэгээд энэ зөвлөлийг Монголын талаас нь би ахалдаг. Нөгөө талаас нь Хятадын Хөгжил шинэтгэлийн хорооны дэд дарга ахалдаг байгаа. Тэгээд энэ 2 байгууллага гарч ирж байгаа.

Дээрээс нь энэ Засгийн газар хоорондын хэлэлцээрийг манай талаас Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд, Зам, тээврийн хөгжлийн сайд, Хятадын талаас Хөгжил шинэтгэлийн хорооны дарга гэсэн ийм түвшинд зурахаар тохиролцоод явж байгаа учраас энэ зурсан байгууллагууд бас хариуцлагыг нь хүлээгээд, хэрэгжилтийг нь хангуулаад явах асуудал байгаа гэдгийг хэлье.

Нүүрс худалдах, худалдан авах гэрээ дээр бол хэмжээний асуудал бол Их Хурлын үндсэн чиг дотор заасан хэмжээгээрээ нүүрс худалдах, худалдан авах гэрээ дотроо яг энэ тоогоороо заагдаад явж байгаа. 5, 5, 5, 6, 6, 20 сая гээд ингээд 16 жилийн асуудал хэмжээ нь бол тэнд орсон байгаа. Үнэ дээр бол бид нар бас саяын энэ хэлэлцээрийг явахад Монголын талын драфт, Их Хурлын чиглэл, Хятадын талын саналууд гээд ингээд нэлээн маргалдаж байгаад маргалдах юу байх вэ саналуудаа явуулж, харилцан солилцож байгаад, тэгээд анхны үнэ дээр нэмэх нь улирлын индекс гээд. Энэ дээр бол Эрдэнэс Тавантолгой ч тэр, яам ч тэр, манай ажлын хэсгийнхэн ч гэсэн энэ ойлголтоор үндсэн чиглэлээ зөрчихгүй гэдэг ийм байдлаар 2 талтай зөвшилцөөд, тохиролцсон гэдгийг хэлье.

Олборлолт дээр бол түрүүн би бас хэлсэн. Энэ олборлолтыг бол Монгол Улсын хууль тогтоомжийн дагуу уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх буюу Бор толгой, Онч хараат 2 дээр бас тендерээ зарлаад явна. Энэ дээр бол бас компаниуд оролцох нь бол нээлттэй. Мэдээж энэ нүүрсийг худалдаж авах талуудаасаа бол түлхүү сонирхолтой оролцоно. Энэ олборлолт дээр. Мэдээж олборлолтын операторын зардал чирэгдлийг бол Эрдэнэс Тавантолгой компани гаргаад, хяналтаа тавиад, хамтран ажиллаад ингээд явна. Энэ зүйл дээр байгаа нарийн заалтуудыг компани хоорондын гэрээ дээрээ бас таны хэлснээр анхааръя.

Р.Сэддорж: Жаргалан гишүүн тодруулж асууна.

Б.Жаргалан: Яах вэ гэрээ дээр тодруулах гэхээсээ илүүтэй саяын тэр дурдагдсан өгүүлбэрийг бол бараг аваад хаячихмаар санагдаад байгаа байхгүй юу.

2 дугаарт энэ 5 дугаар зүйл дээр манайхан болохоор өөрсдийнхөө сонирхлуудыг оруулахыг хичээсэн юм шиг байна л даа. Бусад боомтуудыг холбоно гэхчлэн. Тэгээд тэр дээр сэргээгдэх эрчим хүчний экспортыг дэмжих гэдгийн оронд тоног төхөөрөмж гээд үг орчихсон байгаад байгаа. Энийгээ бас авч хаявал зүгээр байгаад байна.

Тэгээд Гадаад яамныхан ирчихсэн байгаа дээр нэг асуулт байна. Ер нь энэ гэрээний үг, үсэг энэ Засгийн газрын хоорондын хэлэлцээр гээд л манайд урьд нь бас байгуулсан хэлэлцээрүүд байдаг л байлгүй. Энэ дээр бас яг Монголын талын ашиг сонирхлыг хамгаалах тал дээр Гадаад яам ямар бас чиг үүрэгтэй оролцож байна вэ. Яах вэ, энэ хэлэлцээрийн үг, үсэг болон бусад өмнөх, хойдох туршлагууд энэ тэр гээд танайх бас жоохон идэвх санаачилгатай оролцоод явмаар байх юм. Тэгээд энэ дээр нэг тайлбар өгөөч ээ.

Р.Сэддорж: Хариулт 3 Номер.

Л.Мөнхтүшиг: Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг байна. Энэ ажлын хэсэгт Гадаад харилцааны яамнаас анхнаас нь оролцоод явсан. Тэгээд хэлэлцээрийг Засгийн газрын хуралдаанд хэлэлцүүлэх, Байнгын хороонд өргөн барих бэлтгэл ажлын хүрээнд хэлэлцээрийн орчуулах болон агуулгыг хууль тогтоомжтой нь нийцүүлэх ажил дээр бол Гадаад харилцааны яам манлайлах үүрэгтэй оролцсон гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн асуулт асууна.

Н.Батсүмбэрэл: Зам, тээврийн яамнаас асууя. Энэ 2 зам 2 талдаа очоод өөд өөдөөсөө хараад зогсчихсон байж байгаа. 30 метрийн өндөр намтай. Тэгээд манай талаас замаа явуулах юм байна. Мөнгөө өөрсдөө гаргах юм байна. Үүний тооцоо гарсан уу. Хэд орчим төгрөгөөр очиж замаа холбох гэж байгаа вэ. Хэн хийх гэж байгаа вэ. Монголын тал хийх юм байна. Энийг Зам, тээврийн яам хариулж өгөөч.

2 дугаарт нь Гадаад харилцааны яамнаас асууя. Төрийн нарийн бичгийн даргаас. Протоколд оруулаарай. Энэ гэрээ Монгол Улсын эрх ашигт нийцэж байгаа юу. Энийг хариулаад өгчих.

3 дугаарт нь Эрчим хүчний яам. Тэр гишүүдийн яриад байгаа үнэн л дээ. Энэ өгүүлбэрийг уншихаар Монгол хэлний дүрэм хичээлд суусан хүн бол ойлгож байгаа. Болон сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжинэ гэж байгаа юм. Өөрөөр хэлбэл сэргээгдэх эрчим хүчийг биш, тоног төхөөрөмжийг нь дэмжинэ гэж. Экспортын тоног төхөөрөмжийг нь. Тэгэхээр энэ дээр яагаад сэргээгдэх эрчим хүчийг экспортолно гэдэг үг өөрөө ороогүй юм бэ. Одоо эсвэл Монгол хэлний дүрэмд бас өөр байдаг юм болов уу.

Гэрээ маш богино хугацаанд хүчин төгөлдөр болох юм байна. Эргээд маш урт хугацаанд цуцлагдах юм байна. Нэмэлт заалт дээр харахаар. Хэзээ та нарын тооцоогоор гэрээ хүчин төгөлдөр болно гэж та нар тооцож байна вэ. Аж үйлдвэрийн яам. Эрчим хүч биш шүү сая тэр асууж байгаа нь.

Тэгээд энэ гэрээ байгуулагдахад бас нэлээн хүнд нөхцөлүүдийг давж байж, тэгээд мэдээж энэ зам холбох асуудал багтаж байна. Уурхайг өргөжүүлэх асуудал багтаж байна. Үнийн тогтвортой байдлын асуудал багтаж байна. Тэгээд араас нь 2028 оны сонгууль дөхөөд ч юм уу баахан эх орончид гарч ирнэ. Сая манай нөгөө гишүүдийн яриад байгаа. Тэгээд өнөөдөр энэ гэрээ байгуулж байгаа, гэрээг баталж байгаа хүмүүс аягүй бол эх орончид биш болж хувирна. Тэгэхээр энэ мэдээллээ та нар олон нийтдээ хэрхэн өгч байна вэ. Тэгээд сүүлдээ хэн нь эх оронч юм, хэн нь масктай эх оронч юм гэдэг нь ойлгогдохоо больчихдог. Эх орноо худалдаж, хулхидаж явж байснаа маск зүүгээд эх оронч болоод гараад ирдэг. Тэгээд яг энэ эх орныхоо эдийн засгийг хөгжүүлъя, урагшаа явуулъя гэж байгаа хүмүүс нь урвагч, худалч болоод үлддэг. Энэ бол та бүхний одоо мэдээллээ ил тод тавьдаггүй, мэдээллээ нийтэд хүргэдэггүй байдалтай л хамааралтай.

Бидэнд тарааж өгсөн материал бол нэгэнт ил ярьж байгаа юмыг яагаад нэг .../минут дуусав/

Р.Сэддорж: Хариулт 4 номер.

С.Батболд: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Төмөр замын хил холболтын зураг гарсан. Магадлал хийсэн. Нийтдээ энэ төсвийн өртөг бол 976 тэрбум төгрөг гэсэн ийм тооцоо гарсан байгаа. Энэ хэлэлцээрээр бол энэ төслийг хариуцагч нь Эрдэнэс Тавантолгой байгаа. Гэхдээ барих компанийг бол сонгон шалгаруулна. Өнөөдөр Монголд нийтдээ ийм суурь бүтэц барьдаг 80-аад аж ахуйн нэгж байна. Яг үндэсний. Өмнө нь бид бүхэн энэ ковидын үеэс авхуулаад нийтдээ гол болон салбар мянгаад километр ийм төмөр зам барьсан бас монголчуудын туршлага байгаа. Тэгээд энэ дээр бол сонгон шалгаруулалт явагдана.

Р.Сэддорж: 3 номер.

Л.Мөнхтүшиг: Гадаад харилцааны яамны Төрийн нарийн бичгийн дарга Мөнхтүшиг. Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Гадаад харилцааны яам олон улсын гэрээний тухай хуулиар Засгийн газар хоорондын хэлэлцээрийг байгуулах явцад олон улсын гэрээг Засгийн газар хоорондын гэрээний загварт оруулах, хууль тогтоомжид нийцүүлэхтэй холбоотой болон орчуулгатай холбоотой асуудлаар оролцоод явдаг. Энэ хэлэлцээрийн хувьд бол ажлын хэсэгт Гадаад харилцааны яам анхнаасаа орж явсан. Тэгээд Монгол Улсын Их Хурлаас өгсөн тогтоолын дагуу ажлын хэсгийн бүрэлдэхүүнд орж ажилласан.

Тэгэхээр Гадаад харилцааны яамны зүгээс Засгийн газрын хоорондын хэлэлцээрийг Монгол Улсын эрх ашигт нийцэж байгаа, үгүй гэдгийг шууд хэлэх боломжгүй. Учир нь гэрээгээр зохицуулж байгаа асуудал нь өөрөө салбар болон салбар дундын шинжтэй ийм харилцаа байгаа юм.

Р.Сэддорж: 5 номер.

Ц.Туваан: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Өнөөдөр Эдийн засгийн байнгын хороогоор, дараа нь Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороогоор хэлэлцээрт гарын үсэг зурах зөвшөөрлөө авч байгаа. Монгол Улсын хуулиар тийм. Ингээд 2 талаасаа нөгөө талаасаа Хятадын хөгжил шинэтгэлийн хороо, манай талаас Зам, тээврийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн сайд нар зураад, энэ хэлэлцээр хүчин төгөлдөр болно. Энэ хүчин төгөлдөр болсон хэлэлцээрийг дахин Улсын Их Хурал руу соёрхон батлуулахаар орж ирнэ. Ингээд соёрхон батлагдсанаар энэ процесс хэлэлцээрийн процесс дуусна. Үүнтэй зэрэгцээд давхар явж байгаа ажлын хэсэг хоорондын протоколоо бид бүхэн тохироод дууссан байгаа. Энэ протоколыг 2 талын ажлын хэсгийн дарга нар зурж дуусна. Ингэснээр дараа нь компани хоорондын гэрээ явна. Энэ цаг хугацаагаар явах юм бол энэ оны 4 сараас эхлээд бүтээн байгуулалтын ажил эхэлнэ гэж ойлгож болно.

Р.Сэддорж: Батсүмбэрэл гишүүн тодруулж асууя.

Н.Батсүмбэрэл: Гадаад яам тийм итгэлгүй байна гэдэг маш харамсалтай. Өөрөөр хэлбэл Их Хуралд оруулж ирж байгаа гэрээ дээрээ бид бүрэн итгэлтэй байна гэдгээ хэлж чадахгүй байна гэдэг бол маш харамсалтай шүү. Энийг тодруулж асууя 1 дүгээрт.

2 дугаарт Зам, тээврийн яам энэ холболтын царигаа нэг протоколд оруулаад олон нийтэд маш тодорхой хэлээч. Ямар ямар царигаар холбох гэж байгаа билээ. Энийг бас нэгэнт олон нийт үзэж байгаа юм чинь мэдэж авах нь зүйтэй байна.

3 дугаарт Аж үйлдвэрийн яам би тэр юу ярьж байгаад дуусчихсан. Энэ гэрээ нэгэнт бид нар ингээд ил хэлэлцээд байгаа юмыг бас олон нийтэд ил гаргаж болохгүй байсан уу. Албан хэрэгцээнд биш байдлаар.

4 дэх нь Тавантолгой компаниас асууя. Бид очоод үзэхэд болтанай байгууллагын хувьд бол бас нэлээн л бэхжих гээд үзээд байгаа юм байна. Энэ ажилтан, албан хаагчдынхаа нийгмийн асуудлыг хэрхэн анхаарч үзэж байна вэ. Энэ дээр та нар ямар бодлого тавьж байна. Тэрийгээ товчхон хариулж өгөөч.

Р.Сэддорж: 5 номер Туваан сайд.

Ц.Туваан: Энэ албан хэрэгцээнд гэдэг тэмдэгтэй орж ирж байгаа. Тэгэхээр энэ бол Хятадын талаас бол бүр нууцын гэдэг асуудал орж ирсэн. Тэр нь юу гэхээр БНХАУ бол маш олон дэлхийн бүх улсуудтай Засгийн газар хоорондын хэлэлцээр, бусад гэрээ хэлэлцээрүүдийг хийдэг. Бүгдийг нь нууцлалтайгаар хийдэг гээд. Тэгэхээр бид бүхэн бас өөрт байгаа хуулийн боломжийн хүрээнд Их Хурлын дарга, Их Хурлын Тамгын газар, Засгийн газар, Ерөнхий сайд ярилцаад ийм байдлаар оруулж ирж байгаа гэдгийг хэлье. Тэгээд энэ бас нэлээн компани хоорондын дээрээс нь бас тодорхой зүйл заалтуудтай асуудал учраас ийм байдлаар орж ирсэн. Мэдээж үүний өмнө бас бид бүхэн Улсын Их Хурал дээр үндсэн чиглэл батлах хүрээнд бол бас нэлээн их мэдээлэлтэй нэлээн нээлттэй байдлаар бас хэлэлцээд явсан. Олон нийт бас нэлээн мэдээлэл авсан байна лээ.

Р.Сэддорж: 4 номер.

С.Батболд: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Энэ хил холболт өргөн, нарийн 2 цариг зэрэгцэж явна. Өргөн царигаар экспортод, нарийнаар бол импортын бараа орж ирэхээр ингээд 2 цариг хоёулаа зэрэгцэж явахаар байгаа.

Р.Сэддорж: Гадаад яам хариулъя. 3 номер. Хэдэн номер вэ. 3 номер тодорхой хариулаарай.

Л.Мөнхтүшиг: Гадаад харилцааны яам Засгийн газрын бүтцийн 1 нэгж гэдэг утгаараа Засгийн газраас байгуулсан Их Хурлын тогтоолоор өгсөн чиглэлийн дагуу энэ ажлын хэсэгтэй Гадаад харилцааны яамтай холбоотой хуулиар олгогдсон чиг үүргийнхээ хүрээнд ажилласан гэдгийг хэлье.

Тэгэхээр Гадаад яам дангаараа Монгол Улсын эрх ашигт нийцсэн гэрээ юу гэдгийг яг энэ миний хувьд бол шууд хэлэх бас боломжгүй гэдгийг бас та бүхэн ойлгохыг хүсье.

Р.Сэддорж: 7 номер.

Х.Мөнхжаргал: Батсүмбэрэл гишүүний асуултад хариулъя. Эрдэнэс Тавантолгой компани нь компанийнхаа ажилтнуудын нийгмийн асуудлыг хамтын гэрээний дагуу шийдвэрлээд явдаг. Хамтын гэрээгээ бид жил болгон шинэчилдэг. Одоо манай компани дээр 3 үйлдвэрчний эвлэл ажилладаг. Үйлдвэрчнийхээ эвлэлийн бас хүсэл сонирхлыг бид сонсоод, хамтран ажиллах бодлогыг удирдлагуудын зүгээс авч хэрэгжүүлдэг байгаа. 2024 оны эцэст бид хамтын гэрээгээ сая шинэчилсэн байгаа. Үүнд бол уртын ээлжид ажиллаж байгаа манай ажилтнуудын асуудал, гэр бүлд нь чиглэсэн арга хэмжээг аль болох авах, тэгээд ажилтнуудынхаа кемп кэйтерингийн асуудлыг бас саналыг сонсоод шийдвэрлэх зэрэг асуудлуудыг 2024 ондоо бид хийж өгсөн байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Нэмж хариулах хүн байна уу. Тэр орон нутгийн аж ахуйн нэгж, юмнуудыг ажиллуулъя гээд байгаа шүү дээ. Тэрүүгээр дүүрэн хүмүүс, аж ахуйн нэгжүүд байгаа. 21 аймаг, 9 дүүргээс очсон л хүмүүс байгаа даа. Тэгээд тэр хүмүүсийг ажлын байр, ажлыг нь дэмжих, холоос хүмүүсээр очоод л хийчхэж байна уу. Эсвэл тэр хүмүүсийн дэмжлэг туслалцаа ажлын байраар хангах, ажилтай байлгах талаас нь анхаараарай гэдгийг хариулах уу эсвэл зүгээр санал болгож авах уу. Энэ дээр санал байна уу. Хариулах юм байна уу. Туваан сайд.

Ц.Туваан: Энэ дээр бид нар Монгол Улсын Засгийн газрын хэлэлцээрт орж байгаа. Тэгээд мэдээж улсын эрх ашгаа 1 дүгээрт тавиад, Монголчуудынхаа эрх ашгийг 1 дүгээрт тавиад ингээд явна. Улсын Их Хурал дээр маш олон Улсын Их Хурлын гишүүд, тэр дундаа бас энэ үйл ажиллагаа явагдаж байгаа говийн бүсээс сонгогдсон Улсын Их Хурлын гишүүд, Сэддорж дарга нар бас энэ асуудлыг маш олон удаа тавьсан. Энийг бид бүхэн ажлын хэсэг дээрээ энэ хэлэлцээрийн шатанд бүр цаашлаад протоколын шатад хамгийн сүүлд нь 2 аж ахуйн нэгж хоорондын компанийн 3 гэрээ зурах явцдаа бол байнга санаж, энэ асуудлыг албан ёсоор заалт болгож оруулж, цаашид нь хэрэгжилтийг нь хангуулах тал дээр бас байнга ажиллана гэдгийг бас албан ёсоор протоколд хэлье.

Р.Сэддорж: Гишүүд асуулт асууж дууслаа. Хэлэлцээрийн төсөлтэй холбогдуулан үг хэлэх гишүүд нэрсээ өгье. Батчимэг гишүүнээр тасалъя. Бямбасүрэн гишүүн үг хэлнэ.

Ш.Бямбасүрэн: Энэ гэрээ маань өөрөө ер нь дан ганц хил холболтын төмөр зам биш. Ер нь бол яг үндсэндээ нүүрс худалдах, худалдан авах гэрээ л юм байна л даа. Гол юм нь бол. Тэгээд миний ганц хөндөх гээд байгаа юм бол өмнө нь гишүүдийн хэлж байгаа юмнуудыг бүгдтэй нь санал нийлж байгаа юм. Тэгээд ганц нэг хөндөх гээд байгаа юм бол Монголчууд бол өөрсдөө нүүрсийг олборлож чаддаг болчихсон. Энэ бол өөрөө нэг тийм айхтар технологи шаардсан тийм үйл ажиллагаа биш шүү дээ. Тэгэнгүүт гэрээний яг нэг урьдач нөхцөл дээр орчихсон байгаа нэг зүйл нь болохоор Хятадын талаас уурхайн үйл ажиллагааг тэлэх дээр орж ирнэ гээд байгаа юм. Уг нь бол энийг бид нар эдийн засгийн үр өгөөжөө бодох юм бол энэ яг зардал нь бол уг нь яг Монголдоо үлдвэл их зүгээр байгаад байгаа юм. Бид нар ингээд чаддаг юмаа гадаад компанид өгнө гэхээр бас эдийн засгийн дам утгаа бодох юм бол буруу л болчихоод байгаа юм л даа.

Монголчууд бид нар өнөөдөр нүүрсийг олборлож чадна шүү дээ энэ чинь. Ямар ч асуудал байхгүйгээр Монголын компаниуд хийж чадаж байгаа юмыг гадаад компанид өгнө гэдэг энэ заалт бол яг Монголын эрх ашгаас нэлээн ухарсан заалт байна. Тэгээд энийг бид нар юу яах боломж байгаа юм болов уу. Яг одоо энэ зөвшилцөл дээрээс хасуулах тийм боломж байдаг бол тэрийг хасуулмаар байна.

Тэгээд үнэндээ бид нар бол яг л нүүрсний л гэрээ ярьж байна шүү дээ. Ер нь төмөр замаа бид нар өөрсдийнхөө хөрөнгөөр барьчихаж байна. Одоо яг нөгөө хэтэрхий нөгөө 1 талын 1 улсын эрх ашиг орчихсон тийм юу байна л гэж харж байна. Тэгээд энийг өөрчлөөд магадгүй монголчууд өөрсдөө олборлоод, тэр Эрдэнэс Тавантолгойгоос гарч байгаа тэр зардал нь Монгол Улсдаа үлддэг байвал ядаж бас харж болохоор тийм гэрээ байна л гэж харж байна.

Р.Сэддорж: Хассуурийн Ганхуяг гишүүн үг хэлнэ.

Х.Ганхуяг: Өглөөний мэнд хүргэе. Ингээд үндсэндээ бид нар мухар төмөр замынх нь төлөөсийг л төлж байгаа гэрээ байна л даа. Тэгээд олборлолтоос авхуулаад бүх зүйлийг нөгөө тал, айл хийх юм байна. Бид нар хяналтаа сайжруулах, нүүрсээ үнэгүйдүүлэхгүй байх тал дээр онцгой анхаарал тавих хэрэгтэй дээ. Мөн энэ хэлэлцээр бол 3 хэлээр хийгдээд англи хэл нь маргаан үүсвэл англи хэлээ барьж явах юм байна. Тэгээд бид нар Их Хурлаараа ядаж энэ дээрээс нэг санал гаргамаар байна. Одоо бид нар бол Монгол хэлтэй юугаа л

харах ёстой. Дараа нь энэ орчуулгын зөрүү гарвал яг хэн хариуцлага хүлээх вэ гэдэг асуулт тодорхой бус байна.

Тэгээд хэчнээн гоё сайхан кино хийж болно л доо. Одоо үнэнд бол гүйцэгдээд л бид нар явж байна шүү дээ. Энэ чинь хувийн хэвшил аль 10 хэдэн жилийн өмнө өөрөөсөө хөрөнгөө гаргаад, холбоод, нүүрсээ гаргаад, ашиглаад, өнөөдөр энэ жил төрд хүлээж авах ёстой байсан шүү дээ. Энэ жил. Тэгээд энэ 16 сая тонн гэдэг маань үндсэндээ яг ашиглалтад орсноос хойш хамгийн багадаа 50-60 хувь нь энэ компани өөрөө тэр төмөр замаараа нүүрсээ тээвэрлэх юм байна. Ядаж бусад аж ахуйн нэгжүүдийн Эрдэнэс Тавантолгойн гаргасан нүүрс, тэр бусад хувийн хэвшлийн гаргаж байгаа нүүрсийг энэ төмөр зам нь тээвэрлэх ёстой шүү. Тэр дээр хязгаарлалт хийхгүйгээр, дарамт шахалт үзүүлэхгүйгээр онцгой анхаарна шүү. Ганцхан Хятад энэ авч байгаа компанийн нүүрсийг тээвэрлээд эхлэх вий дээ. Тэгээд л тээврийн зардлынхаа өртгөөсөө хамаараад нүүрсний өртөг дээрээ тэр чинь нөлөөлнө. Бүгдийг нь өрсөлдөөндөө татаад унагаана шүү дээ. Тийм бид нар хэмжээний л одоо хэлэлцээр хийх гэж байгаа шүү дээ. Тэр тал дээр онцгой анхаарахгүй бол бусад айлуудаа дарамталдаг, шахдаг, өрсөлдөх боломжгүй болох вий дээ. 16 жил гэдэг бол богино хугацаа биш шүү. Энэ бол одоо үүнээс чинь хамаараад манай төсвийн орлого, хүүхдийн мөнгө, тэтгэвэр, төрийн албан хаагчдын цалин гээд асар олон юм хамаарна шүү дээ. Хойрго хандах вий дээ. Тэгээд та бүхэн минь энэ дээр онцгой анхаараарай. Тэр кино бол надад бол таалагдсангүй шүү. Тэгээд та нар үнэн үнэнээр нь гаргах хэрэгтэй шүү. 10 жилийн мухар төмөр зам. Тэр Зүүнбаяны төмөр замаар одоо нэг ч юм зөөдөггүй. Үнэн нь үнэнээрээ сайхан шүү. Одоо өдийд бид нар төмөр зам хүлээж авах ёстой байсан шүү. Энэ жил. Холболт хийчихсэн төмөр зам. Жилд 30 сая тонн зөөдөг төмөр зам. Төр үнэгүй хүлээж авах байсан. Тэгээд тэрнийхээ төлөөсийг бид нар ингээд ийм хэмжээний хэлэлцээрээр төлөөд сууж байна шүү дээ.

Р.Сэддорж: Лувсанжамц гишүүн үг хэлнэ.

Г.Лувсанжамц: Өдрийн мэнд хүргэе. 2, 3 санал байна. Хятадын талаас ингээд хэлэлцээр дээр ийм санал тавьсан, тэгсэн, ингэсэн гээд амаараа тайлбарлаад л байна л даа. Ингээд 2 улсын хооронд хэлэлцээр хэлэлцэж байгаа бол эхлээд манай талаас ийм санал явууллаа, ийм хариу ирлээ. Ийм зүйл, заалт дээр нь манай тал дахиад ийм сөрсөн санал тавилаа. Тэр дээр ийм хариу ирлээ гэсэн байдлаар нэг ийм явцыг харуулахгүй болохоор шууд орж ирээд, энэ гэрээ хэлэлцээрийг бариад явнагэхээр бид нар яалт ч үгүй ингээд хар төрөөд байна шүү дээ. Бид нар аль хүртэл ер нь хэлэлцээр дээр хичээсэн юм. Засгийн газар ер нь аль хүртэл яваад, айлын тал чинь ингээд 2 тал хэлэлцээр хийж байгаа юм чинь бас энийг нь ингэмээр байна, тэгмээр байна гэсэн тийм саналуудаа өгөөд явж байх ёстой. Тэр нь нөгөө та хэдийн маань хийсэн ажлын үр дүн энэ тараасан материал дээр харагдахгүй байгаад байгаа нь та хэдийгээ уг нь бол ингээд дэмжмээр байдаг. Тэгээд тэр мэдээлэл бүрэн биш байгаад байгаа болохоор энэ төрөө түшээд сууж байгаа, түмэн олноо төлөөлөөд сууж байгаа энэ хүмүүс чинь ингээд хардлага төрөөд байгаа байхгүй юу. Тэгэхээр тараах материал дээрээ ийм хэлэлцээрийн явцыг харуулсан тийм байдлаар материал байхгүй бол бас зөв шийдвэр гаргахад бол тийм материал хэрэгтэй байна. Энэ яах вэ өнөөдөр бол яах вэ, дэмжиж яваад дараа нь Улсын Их Хурал дээр соёрхон батална гэсэн зүйл байгаа болохоор тэр яв явцад ч гэсэн бүрэн мэдээллээр хангаж өгөөч ээ гэсэн тийм зүйл байгаад байгаа юм.

2 дахь нь болохоор энэ 5 дугаар зүйл дээр сая хэлж байсан. Эрчим хүчний тоног төхөөрөмжийн экспортыг дэмжинэ гээд энэ манайд угаасаа үйлдвэрлэдэггүй юмыг экспортлох боломжгүй юм чинь энэ тоног төхөөрөмжийн гэдэг үгийг нь шууд хасаад, эрчим хүчний экспортыг сэргээгдэх эрчим хүчний экспорт гэдэг байдлаар манай талаас санал тавиач ээ. Тэгээд 6-гийн нэмэлт заалтын 5 дугаар хэсэг дээр байгаа хэлэлцээрийн хэлэлцээ үнэлгээ болон хэрэгжилтийн явцад нэг талаас нөгөө талдаа дамжуулсан мэдээллийг талууд зөвхөн дотоод хэрэгцээндээ ашиглах энэ заалтыг бас манай талаас боломжгүй байна гээд санал тавимаар байх юм. Одоо ингээд нууцын зэрэглэлд ороод ч юм уу, янз бүрийн ялангуяа энэ үнэлгээ болон хэрэгжилтийн явцын мэдээлэл гэж байгаа шүү дээ. Энийг бол нээлттэй байдлаар хоорондоо ярилцахгүй бол дахиад л нүүрсний хулгай гээд хардалт маш их төрүүлнэ. Энийг нь хасъя гэсэн саналыг та хэдээсээ тавиач тэгэх үү. Тэгээд засаад оруулж ирье гэсэн тийм зүйл байгаад байгаа юм.

Тэгээд энэ уурхайн ам үнийг хил үнэ болгох, нүүрсийг сорчлохгүйгээр холимог байдлаар гаргах гэсэн ийм зүйлүүдээ ч гэсэн манай талаас энэ гэрээнийхээ хэлэлцээр дотор ингээд тусгаж байна гэсэн тийм нэг хичээл зүтгэл гэх юм уу тийм зүйлүүдийг нь бас бид хэддээ харуулчихвал бас дэмжээд явчихвал их хэрэгтэй байгаа шүү гэсэн тийм санал байна. Тэгээд өнөөдөр хэлсэн энэ зүйлүүдийг бас Эдийн засгийн байнгын хорооноос бас нөгөө материалыг нь авахдаа явцыг нь бас хармаар байна гэсэн тийм зүйлийг, мэдээллийг нь давхар ирүүлж байж хэлэлцэнэ гэсэн байдлаар шаардлага тавьж байгаад хэдүүлээ бас ажиллах юм бол илүү үр дүнтэй болов уу гэсэн ийм санал байна.

Р.Сэддорж: Баярлалаа. Отгоншарын Батнайрамдал гишүүн үг хэлье.

О.Батнайрамдал: Бас танилцуулга дээр дурдсан байгаа юм л даа. Тэгэхээр ер нь энэ төмөр зам Гашуунсухайтын төмөр зам холбогдох юм бол үүнээс гадна Гашуунсухайтаас гадна Шивээхүрэн, Ханги, Бичигт өөр Гашуунсухайтаас илүү хэмжээний нүүрс төмөр замаар гарах потенциал байгаа байхгүй юу. Одоо та нарын презентаци дээр байна л даа. 2030 он гэхэд төмөр замаар бид нар 80 сая тонн нүүрс гаргая. Гашуунсухайтаар 30, үлдсэн Шивээхүрэн, Ханги, Бичигт 3 нийлээд Гашуунсухайтаасаа илүү 50 сая тонныг бид нар гаргах потенциал байгаа юм. Тийм болохоор 2 улсын Засгийн газар хоорондын уг нь яг энэ хэлэлцээр дээрээ бусад асуудал яг сая гишүүд яриад байна л даа. Эрчим хүчний тоног төхөөрөмж гээд бүр илүү дэлгэрэнгүй орж болж байгаа юмыг чинь бусад хил дамнасан яг энэ Ханги-Мандал, тэгээд Бичигт, Шивээхүрэн гээд уг нь бас дурдаад оруулчихвал бусад гэдэг ганцхан үг дотор ингээд нуугдчихсан юм шиг болох гээд л байна л даа. Тэгэхээр явж явж хамгийн том ач холбогдол нь энэ Гашуунсухайтаас гадна Монгол Улс бусад маш потенциалтай томоохон ордуудыг төмөр замаараа холбох энэ потенциал бол Гашуунсухайтаас илүү том бас байж болох байхгүй юу. Потенциалаараа. Тийм болохоор бусад нь ингэж дэлгэрэнгүй орж байгаа юмыг чинь бусад төсөл гэхгүй уг нь тэр дэлгэрэнгүй орчих юм бол 2 улсын Засгийн газрын хэлэлцээр ингээд биелээд, түүний биелэлтийг хангаад явахад илүү ойлгомжтой болох болов уу гэсэн ийм нэг зүйл байгаа юм. Тэгэхээр Гашуунсухайтаас гадна бараг Гашуунсухайтаас илүү ач холбогдолтой байж болох зүйл учраас энийг дахин дахин яриад байгааг ойлгоно биз дээ.

2 дугаарт бид нар сая энэ томоохон мега төслүүд дээр харж байхад ч гэсэн хамгийн гол зүйл яах вэ бид нар өөрсдөө бас ийм том мега төслүүдийг урагш нь явуулах ч юм уу тийм туршлага багатай л даа. Гэхдээ хяналт явж явж хамгийн

чухал зүйл байна. Бид нар хийж чадахгүй юмыг чинь гэхдээ яг мэргэжлийн, хөндлөнгийн, ямар нэгэн ашиг сонирхолгүй яг Засгийн газартай шууд гэрээтэй мэргэжлийн байгууллагаар хяналт тавиулж байж, бид нар тэр чиг үүргийг хангах боломжтой болох юм. Тэгэхээр хяналтыг бол яг гэрээ дээрээ бол 2 тал Монголын тал дахь төмөр замын хяналтыг бол тэр хил холболтын хийгдэх ажлыг Монголын тал өөрсдөө хариуцна шүү дээ. Хариуцна гэж тусгасан байна. Хятадын талд болохоор Хятадын тал нь хариуцна. Зөв. Тэгэхээр хяналтыг яг мэргэжлийн байгууллагаар нь яг олон улсын чанартай тэрийг хийдэг байгууллагаар нь заавал хийлгээрэй гэж хүсмээр байна. Эрдэнэс Тавантолгойн зүгээр нэг хяналтыг хариуцсан газрын дарга хийх биш.

Яагаад гэхээр бас энэ төмөр замын холболт дээр ч гэсэн Хятад, Монгол талаасаа бид нар газар дээр нь очиж ажиллахад энэ чинь өндөр намаасаа хамаараад зүгээр нэг адилхан холбогдох биш нэлээн тойруу байдлаар бас нэлээн технологийн хувьд ч гэсэн ур чадвар шаардсан бүтээн байгуулалт болно гэж ойлгосон. Тэгэхээр энэ дээр тавих хяналт магадгүй зүгээр нэг төмөр замаасаа илүү ач холбогдолтой, зүгээр шулуун шугамаар барьж байгаа төмөр замаасаа илүү ач холбогдолтой байх гэж ойлгоод байгаа юм. Тэгэхээр энэ дээр Туваан сайд анхааралтай яг энэ хяналтыг мэргэжлийн байгууллагаар болохгүй бол гаднын мэргэжлийн байгууллага авсан ч болно шүү дээ. Гуравдагч орны. Тэгэхээр яг энийг заавал хийлгээсэй гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа юм. Тэгэхээр энэ дээр алдаа гарах юм бол дараа нь маш хүнд алдаа болно л доо. Тийм учраас бидний бусад мега төслүүдээс суралцсан нэг зүйл ч гэсэн ер нь Энэтхэгийн энэ газрын тос боловсруулах үйлдвэр дээр ч гэсэн хяналтыг яг мэргэжлийн хөндлөнгийн байгууллага заавал хийх ёстой. Энийг маш чанартай хийх ёстой юм байна гэдгийг бид нар олуулаа ойлгоод байгаа шүү дээ. Тэгэхээр бусад төслүүд дээр гарч байгаа алдаа, дутагдал ч юм уу тэр зүйлүүдээс суралцах тусам л бид нар улам сайжрах болно. Тэгэхээр ер нь прожект менежмент буюу төслийн менежментийг цаашаа авч явахад бид нарт суралцах зүйл маш их юм байгаа юм байна лээ. Тэгэхээр энийгээ тэр дор нь ажил хэрэг болгоод явах юм бол бид нарт илүү урт хугацаандаа хэрэгтэй болов уу л гэж бодож байна. Баярлалаа.

Р.Сэддорж: Пүрэвжавын Сайнзориг гишүүн үг хэлнэ.

П.Сайнзориг: Баярлалаа. Тэгээд мэдээж энэ төслийг нь сая Батнайрамдал гишүүн бас хэлчихлээ л дээ. Би ч бас асуусан. Ач холбогдол нь яах вэ, бусад боомтуудын хил холболтыг л хийж, Монгол Улс бас урд хөрштэйгөө олон гарцтай, үүгээрээ зарим боомтоор нь бас барилгын материал, бусад зүйлээ татчихдаг, экспортоо бас хийчихдэг ийм л ач холбогдлынхоо үүднээс яаж байна. Тэрнээс энэ төсөл бол бантан шүү. 10 хэдэн жилийн хугацаанд сая Туваан сайд хэллээ шүү дээ. 18,5 тэрбум долларыг олох боломжоо бид нар алдсан. Би бол Туваан сайдыг маш бага дарж хэлж байна гэж бодож байгаа юм. Энэ боломжийг үгүй хийсэн хүмүүс өнөөдөр ардын баатар үүнтэй зэрэгцээд ардын баатар мэт болчихсон кино зохиол хийгээд байж байна. Тэр кинонд нь Засгийн газар өөрсдөө очоод тоглоод байна. Би болиорой гэж хэлж байгаа юм. Одоо энд зарчим ярьдаг, зарчим тогтоох гээд явангуут нь тэнд нэг хулгай хийж Монгол Улсыг хорлосон хүмүүстэй зэрэгцэж суугаад, өнөөдрийн бараг аврал юм уу хаашаа юм. Монгол Улсын аврал болсон юм уу тэд нар. Тийм юм бол байхгүй шүү. Тэгээд тэд нарыг хаашаа юм ингэж хорлосных нь төлөө бараг Монгол Улсын эдийн засгийг 30 жилээр хорлочоод байгаа хүмүүсийг өнөөдөр ардын баатар мэт кино зохиол хийгээд байгаад ерөөсөө үнэхээр харамсаж байна. Тэгээд тэд нар нь энд яг зөв зарчим ярьсан хүн болгоныг

Хятад гэж янз янзаар нь хоч нэр өгч кино зохиол бичдэг ийм зүйл байж болох юм уу. Ийм зүйл дээр харин Засгийн газар болон энэ яамнууд маань зарчимтай хандаарай. Төрийн ажил хийж байгаа шүү та нар. Хэт бас төрийн ажлыг улс төрийн өнцгөөс нь аргалж байгаад, тэд нарыг нь намдааж байгаад, энийг явуулъя гэдэг ч юм уу ийм өнцгөөс битгий хандаад байгаарай. Би энийг бол хатуу хэлмээр байна. Тэд нар нь сүүлдээ хүн болгоныг нэр хоч өгч болдог. Дараа нь эдийн засгийг яг бодит байдлаар өнөөдөр 12, 13 жил зогсоочоод, дахиад 16 жилийн асуудлыг ярьж байж ардын баатар болсон, Монголын хувь заяаг аварсан ч гэх шиг битгий ийм юман дээр Засгийн газар өөрөө үе үеийн энэ удирдлагууд байсан хүмүүс очиж тоглоод янз бүрийн юм яриад байгаарай. Энд миний бас олон л хүмүүс. Би энэ хэлэлцээр дээр орж явж байсан юм. Үүнээс ч илүү бололцоонуудыг бас хэлэлцээрийн хувьд хийвэл хийчихээр л байсан. Дандаа цаг хугацаа алдаж Монголчууд ийм л байдалтай байсны бас гор шүү.

Тэгээд би бас энэ дээр Туваан сайдад л хэлж байгаа юм. Яг үүнтэй зэрэгцээд пи арын сонин юм явдаг. Дуугарсан, зарчим ярьсан хүмүүс нь дандаа хог болж хоцордог. Энэ зүйлүүдийг гацааж, Монгол Улсын нүүрсний зах зээлийг ОХУ бусад улсад тавьж өгсөн энэ эдийн засгийн боломжийг алдсан, байгаль орчныг сүйтгэсэн, дараагийн 16 жилийн боломжийг алдагдуулсан нөхөд баатар болоод тэгж явна гэдэг дээр бол би бүр хатуу хэлмээр байна шүү.

Энэ дээр тэгээд дотоодын аж ахуйн нэгж, байгууллагыг туслан гүйцэтгэгчээр оруулахад бас анхаарна биз дээ. Тэгээд ийм л зүйлүүдийг би хэлмээр байна. Тэгээд ер нь зүгээр яах вэ, сүүлийн үед итгэл найдвар бол бага төрж байна. Ураны төслийг зогсоосон, авлига авсан хүн Засгийн газрын Хяналтын газрын газрын дарга ч хийж байх шиг. Маш олон асуудалд оролцсон хүн Эрдэнэс Тавантолгой дээр очоод Бүтээмж хяналтын захирал болчихсон ч байх шиг. Бүтэхгүй шүү. Үнэхээр энэ том төслүүдийг явуулъя, жоохон хариуцлагатай бусад юун дээр зарчим тогтооё гэж байгаа бол Засгийн газар, Туваан сайд энэ асуудлыг хариуцаж байгаа АН, Ардын нам, ХҮН нам хамтарч болно. Тэгэхдээ бас зарим зүйл дээрээ жоохон зарчимтай байгаарай. Удаа дараагийн янз янзын асуудалд оруулчихсан хүмүүс чинь энэ том төслүүдийн мега төсөл дээр бүтээмж хариуцаж, хяналт тавина. Одоо арай л бас одоо ингээд яахаар дөнгөж орж ирчхээд та нар энэ тэр гээд хөшигний ард тэгээд байгаа юм. Тэгэхдээ ярихаа хүрвэл ярина. Би нэрийг нь ч хэлж чадна. Үүрийнтуяа, Пунцаг мэтээр ингэж энэ том том төслүүдийг бол удирдуулж хянуулна гэж бол байхгүй шүү дээ. Тэгчхээд энэ дээр өнөөдөр авлигатай тэмцэнэ.../минут дуусав/

Б.Жаргалан: Энхтүвшин гишүүн.

Д.Энхтүвшин: Энэ хэлэлцээрийн төслөөс харахад бол энэ бол эн тэгш гэрээ хэлэлцээр биш байна. Тэгэхээр 8 зүйл дээр энийг сайжруулахгүй бол би энийг дэмжих бололцоогүй гэдгээ хэлье.

1 дүгээрт нь болохоор Улсын Их Хурлын тогтоолын гарчиг нь бол Гашуунсухайт-Ганц модны хил дамнасан төмөр замын бүтээн байгуулалтын хэлэлцээрийг байгуулахад баримтлах үндсэн чиглэл гэж гарчигласан бол гэрээний агуулгаа өөрчлөөд дээр нь уурхайн хүчин чадал, нүүрсний худалдааг гол чухал мэтээр ингээд оруулсан байна. Тэгэхээр энийг өөрчлөх хэрэгтэй байна.

2 дугаарт энэ Засгийн газар хоорондын хэлэлцээр дээр Хятадын Чайна Энержи хөрөнгө оруулалтын компанийн хамаарал бүхий этгээдтэй хамтран ажилладаг Хятадын бүх компаниуд орж ирэхээр болчихсон байна. Ийм одоо жишээлбэл гэрээ, үүнийгээ хязгаарлах хэрэгтэй байна.

3 дугаарт нь энэ Улсын Их Хурлын тогтоолын гол агуулга бол хил холболтын төмөр зам л чухал байсан болохоос биш энэ заалт дээр болохоор нүүрсний гэрээ уурхай нь чухал юм шиг. Тэгээд тэрийгээ хийхгүй бол энэ төмөр замыг чинь барихгүй гэсэн ийм агуулгатай. Энийг өөрчлөхгүй бол дэмжих боломжгүй.

4 дүгээрт нь энэ нүүрсний үнийг FCA уурхайн ам гэдэг ийм байж болохгүй. Монгол ААН-үүд, Монгол залуучууд, Монгол компаниуд туслан гүйцэтгэгч хийж, энэ ажлууд чинь чадах ажлуудаа яагаад хүнд өгөөд байгаа юм. Энийг бид нар өөрсдөө хийх ёстой. Энэ бололцоо боломжуудыг тэгээд Хятадын компаниудад таатай нөхцөл олгоно гэж ийм байж болохгүй шүү дээ. Монгол өөрсдөө аж ахуйн нэгжүүдээ болохоор шалгуур тавьдаг мөртөө Хятадын компаниудад таатай нөхцөл олгоно гэдэг ийм нөхцөл байж болохгүй. Энийг хасахгүй бол дэмжих бололцоо байхгүй.

5 дугаарт нь саяын энэ Хятадын компаниудыг дэмжих заалтыг авахгүй бол дэмжих бололцоогүй.

6 дугаарт нь дахиад бас Хятадын сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн компаниуд экспортыг дэмжих. Тэгээд энэ 5 дугаар заалт дээр байгаа заалтыг хасахгүй бол дэмжих бололцоо байхгүй. Энэ дээр бас уялдуулаад хэлэхэд Улсын Их Хурлын тогтоол дээр орсон цөөхөн хэдхэн яг одоо жишээлбэл үүрэг өгсөн заалтууд байгаа. Тэд нарыг хасангуутаа хаанаас нь мэдэгдэхгүй, тэнд ороогүй заалтуудыг оруулж ирчихсэн байна. Ямрыг нь хасаад, ямрыг нь нэмчихсэн юм гээд. Одоо энэ дээр жишээлбэл боомттой холбоотой заалтууд байгаа. Шивээ хүрэн-Сэхээ, Ханги-Мандал, тэгээд Байтаг, Улиастай, Бичигт-Зүүн хатавч гэдэг заалтууд байсан. Энийг нь хасчихсан. Дээр нь нүүрсний гүн боловсруулах, говийг усжуулах, цөлжилттэй тэмцэх эд нар гэсэн заалтууд байсан. Эд нарыг нь хасчхангуутаа орон сууц болон эрчим хүчний нүүрсний гэсэн 2 заалтыг оруулсан. Бусдыг нь хасчихсан. Тэгэхээр Улсын Их Хурлын тогтоолыг бид нар дураараа ингэж олонхоороо шийдсэн асуудлыг би ингэж өөрчилж чадахгүй. Тэгэхээр энийгээ Улсын Их Хурлын тогтоолд нийцүүл гэж хэлмээр байна.

Дараагийн заалт нь болохоор энэ нууцлалтай холбоотой. Хятадын тал үнэхээр нууцлах хэрэгтэй бол тэгвэл энэ хэлэлцээрийг ерөнхий болгоод, тэрийгээ нууцлаад яг энэ жишээлбэл аж ахуйн нэгжтэй холбоотой ч юм уу, нарийн детальтай холбоотой заалтуудыг ингэж оруулж ирэнгүүтээ нууцлалд оруулна гэж ийм байж болохгүй. Бид нарын хувьд бол олон жил жишээлбэл Эрдэнэс Тавантолгойн бараг бүх захирлууд шоронд орсон. Өөрөөр хэлбэл энэ том компани бол улс төрийн хэрэгсэл болдог, улс төрчдийн түрийвч болдог, улс төрийн намуудын түрийвч болдог учраас энэ эрсдэлээс салах үүднээс бид нарт бол энэ ил тод байх зайлшгүй шаардлага байгаа юм. Энэ буцаад улсын тусгаар тогтнол, эрх ашигтай уялдах учраас энийг ингэж нууцлах зайлшгүй шаардлага байхгүй гэж үзэж байна. Энэ нууцлалын заалтыг байхгүй болгох хэрэгтэй.

Дараачийн нэг заалт нэмэх хүсэлтэй байна. Нэмэлт заалт дээр авлигатай холбоотой заалт. Хэрвээ энэ гэрээ хэлэлцээртэй холбоотой гэрээний талууд энэ

дээр бол Хятадын төрийн өмчит компаниуд байна. Монголын компаниуд байна. Үүнтэй холбоотой авлигатай, эсвэл ямар нэгэн улс төрийн хүчний юм уу нөлөөллүүд энэ гэрээнд нөлөөлж давуу тал ийм байдал олгосон бол энэ гэрээг цуцлах ёстой ийм заалт оруулах хэрэгтэй байна. Бид нар үүнээс айхгүй гэрээгээ хийх ёстой.../минут дуусав/

Б.Жаргалан: Мэндбаярын Мандхай гишүүн байхгүй байна. Пүрэвийн Батчимэг гишүүн.

П.Батчимэг: Та бүхэнд энэ өдрийн мэнд хүргэе. Тэгээд өнөөдөр Байнгын хороогоор энэ Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, тэгээд нүүрс худалдах, худалдан авах, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх гэсэн 3 цогц томъёоллоор батлагдах ийм хэлэлцээрийн төслийг бол хэлэлцэж байна. Мэдээж Байнгын хорооны гишүүдийн ярьж байгаа саналуудыг сонсоход бол үнэхээрийн ажлын хэсэг, холбогдох яамдын ажлын хэсэг бол анхаарч, бас засаж сайжруулах, хасахыг нь хасаж, нэмэхийг нь нэмж сайжруулах тал дээр бас онцгой анхаарч дахиад бас нэг ажиллаж үзэх хэрэгтэй байх гэж би үзэж байна.

Тэгээд ер нь бол энэ Гашуунсухайт-Ганцмод төмөр зам нарийн, бүдүүн цариг. Энэ мега төслийн хамгийн нэн тэргүүнд яригдаж, урагшилж хөдлөх гэж байгаа энэ төслийг бол явуулах үнэхээр маш чухал хэрэгтэй. Тэгээд энэ хэлэлцээр өөрөө бас манай яамдын ажлын хэсгийн бас уйгагүй, нэлээн цаг хугацаа шаардсан ажил болсон нь бол мэдээж дамжиггүй. Засаж сайжруулах юмыг бол хийх хэрэгтэй гэж үзэж байна. Тэр зөвхөн энэ төмөр замын асуудал төдийгүй тэгээд энд чинь одоо нүүрс худалдах, худалдан авах, тэгээд уурхайн хүчин чадлын асуудал цогцоороо ороод ирж байгаа нь бол надад бол бас таалагдаж байна. Үнэхээр.

Цаашид анхаарах сая Энхтүвшин гишүүний хэлээд байгаа 2 удаагийн энэ санал дээр л гараад байгаа юм л даа. Тийм ээ. Хятадын талын нөгөө талын энэ эрчим хүчний нүүрс сэргээгдэх эрчим хүчний тоног төхөөрөмжийн асуудал яагаад нөгөө талын асуудлууд түрүүлж нэлээн ингэж юунд орж ирээд байгаа юм бэ гэдэг тэр эрх ашгийн хувьд орж ирээд байгаа юм бэ гэсэн энэ асуудал их анхаарал татаж байгаа юм. Тэгэхээр бодвол Туваан сайд, Дэлгэрсайхан сайд энэ тэр энийг бас анхаарч үзэж байгаа байх гэж би бодож байна. Энэ хэлэлцээр батлагдаад, гэрээ батлагдах юм бол хүчинтэй болсон цагаас хойш 16 жилийн туршид үйлчлэх юм байна. Тэгээд ер нь энэ хэлэлцээрийн үр дүнд бий болох тогтвортой эдийн засгийг бий болгох, тэгээд араас нь урган гарч байгаа дотоодын нийт бүтээгдэхүүн, энэ Монгол иргэдийн амьдрах ганц асуудал бол энэ уурхайгаас Тавантолгой, Эрдэнэс Тавантолгой энэ нүүрсний олборлолтоос, нийлүүлэлтээс хамаарах учраас энд үнэхээрийн бид хүч тавьж, санаа тавьж энэ зорилгодоо хүрэх олон бодит ажлуудыг бол хийх ёстой. Тэгэхээр анхнаасаа энэ хэлэлцээр, тэгээд дагасан протокол, тэгээд араас нь орж ирэх гэрээ энэ юмнуудыг бол үнэхээр нэлээн чадвар чадамжтай нэлээн бодсон, улс орны эрх ашиг, ард түмний эрх ашиг энэ бүгдийг үнэхээр хийж чадах юм бол энэ үр өгөөжөө өгөх ийм том төсөл, том бүтээн байгуулалт болох юм гэж харж байгаа юм.

Тэгээд ер нь бол гишүүдийн гаргасан олон чухал саналуудыг бол үнэхээр авч тусгах ийм шаардлагатай гэсэн саналтай байна.

Р.Сэддорж: Батбаярын Жаргалан гишүүн үг хэлнэ.

Б.Жаргалан: Мэдээж хэрэг хэлэлцээрийг талууд гарын үсэг зураад, соёрхон батлуулахаараа дахиад Их Хуралд оруулж ирнэ. Тэгэхээр сая гишүүдийн дурдаад байгаа тогтоол батлагдах үед яригдсан зүйлүүд болон сая өнөөдрийн хурал дээр ч гэсэн яригдаж байгаа зүйлүүдийг бас энэ хэлэлцээрийн төсөлд нэмж тусгаад, оруулж ирвэл сайн байна гэдэгтэй бол санал нэг байна.

Тэгээд ер нь бол өнгөрсөн хугацаанд энэ гэрээ хэлэлцээртэй холбоотой асуудал дээр үүсэж байгаа, нийгмийн дунд явж байгаа хэлэлцүүлэг бол ирээдүйд энэ хэлэлцээр, үүнтэй холбоотой гэрээнүүд Монгол Улсын эдийн засагт ямар ач холбогдолтой вэ, цаашид ер нь бол эдийн засгийг хэр хэмжээгээр тэлэх вэ, үүнтэй холбоотойгоор хэчнээн ажлын байр бий болох юм, хэдий хэмжээний орлого орж ирэх юм гэдгээсээ илүү өмнө нь хэн гацаасан бэ, хэн хэн тээг тавьсан бэ энэ тэр гэх мэтчилэн ийм хойшоо харсан тийм хэлэлцүүлгүүд маш их явсанд бол бас харамсаад байгаа юм. Яагаад гэхээр бид нар одоо урагшаа харсан зүйлүүд дээр илүү ач холбогдол өгч, энэ хэлэлцээр дээр аль болох эх орныхоо эрх ашгийг 1 дүгээрт тавьсан байдлаар хэлэлцээрийг хиймээр байгаад байгаа юм. Өнгөрсөн хугацаанд бол Засгийн газрын гишүүд ч гэсэндээ бас хариуцлагагүй байдлаар мэдэгдлүүд хийсэн талууд бол байгаад байгаа. Хятадын тал бол боломжоо алдчихсан байдаг юм. Тийм учраас бид нар ингэж буулт хийхээс өөр аргагүй байна гээд. Тэр Хятадын талын ямар боломж алдсан энэ тэр гэдэг нь бол тэдгээр хүмүүсийн асуудал шүү дээ. Тэгэхээр Монгол Улсын Засгийн газар, Монгол Улсын Их Хурал бол юуны өмнө Монгол Улсын эрх ашиг, Монгол Улсын цаашдын боломж бололцоог л харж үзэж энэ хэлэлцээрт бол ормоор байгаад байгаа юм. Тэгэхээр энэ асуудал дээр та бүхэн маань яг л энэ өнцгөөс асуудалд хандаасай гэж хүсэж байгаа юм.

Тэгээд сая хамааралгүй асуудал боловч Сайнзориг гишүүн бас их хариуцлагагүй мэдэгдэл хийлээ. Тэгээд өнгөрсөн хугацаанд бол Монгол Улсын Засгийн газрын гишүүд, Улсын Их Хурлын гишүүд ямар ч тийм нотлох баримтгүйгээр тодорхой хувь хүмүүсийн нэрийг дурдаад, тэгээд янз бүрийн асуудалд холбогдсон, авлига авсан, эсвэл ингэсэн, тэгсэн энэ тэр гээд ийм хариуцлагагүй байдлаар мэдэгдлүүд хийгээд, хувь хүмүүсийн нэр төрд халдаад байгаа нь бол ёстой зохимжгүй байгаа юм. Тэгээд цаашид бол энийгээ болих хэрэгтэй байна.

Улсын Их Хурлын гишүүн гэдэг, Засгийн газрын гишүүн гэдэг бол тодорхой нотлох баримт дээр суурилсан байдлаар л хувь хүний нэр усыг хэлнэ үү гэхээс биш ийм сургаар, аль эсвэл ямар нэгэн таамаглалаар тодорхой хувь хүмүүсийн нэрийг барьж ингэж нэр хүндэд нь халдмааргүй байна Сайнзориг гишүүн ээ. Үгүй ээ үгүй. Францын шүүх дээр ямар ч тийм хувь хүмүүсийн нэр ус бол байхгүй байгаад байгаа. Тэгэхээр та нар ингэж олон улсын асуудал дээр хүртэл өөр хүмүүсийн нэрийг барьж, өөр гуравдагч улс орны нэрийг барьж, гуравдагч улс орны шүүхийн нэрийг барьж хувь хүний нэр төрд халдахаа болиорой. Тэгвэл тэр бичгээ гаргаад аваад ир. Үгүй. Та нар яахаараа хүмүүсийг авлигач энэ тэр гээд янз бүрийн байдлаар дууддаг юм. Та нарт хэн тийм эрх өгсөн юм. Энэ Монгол Улсад хүний эрх, эрх чөлөөг хуулиар хамгаалдаг улс орон шүү дээ. Хүний нэр төрийг хуулиар хамгаалдаг улс орон шүү дээ. Тэгэхээр ийм байдлаар хариуцлагагүй баймааргүй байна. Тэгэхээр юу болж байна вэ гэхээр бид нар яг аливаа асуудалд ийм объектив байдлаар хандахгүйгээр, дандаа өнгөрсөн, баларсан, эсвэл ямар нэгэн байдлаар хувь хүмүүсийн асуудлыг оруулж ирсэн байдлаар ингэж хэлэлцүүлэг өрнүүлэх тоолонд яг үндсэн асуудлаасаа анхаарлыг холдуулаад, яг

Монгол Улсын эрх ашиг хаана байгаад байгаа юм. Энэ хэлэлцээр байгуулагдсанаар бид ямар давуу талтай болох гээд байгаа юм гэдэг зүйлүүд умартагдаад, тэгээд хэн нь яасан бэ гэдэг нэг ийм сонин эцэс төгсгөлгүй маргаан руу ороод байгаа байхгүй юу. Тэгэхээр цаашдаа бол хэдүүлээ бас ажил хэрэгч баймаар байна. Тэгээд аливаа асуудалд ажил хэрэгч байдлаар ярьж, аливаа асуудал л дээр юуны түрүүнд эх орныхоо ашгийн эрх ашгийг л .../минут дуусав/

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүн, Мандхай гишүүн нарыг нэмээрэй. Батсүмбэрэл гишүүн үг хэлнэ.

Н.Батсүмбэрэл: Ер нь сая тэр Гадаад яам дээр би шүүмжлэлтэй хандаад байгаа юм. Гадаад яам энэ дээр бас гадаад улс оронтой байгуулж байгаа хэлэлцээрт тодорхой байр суурьтай байх нь бол оновчтой байх гэж бодож байгаа.

Тэгээд сая гишүүдийн хэлээд байгаа Монгол, Англи, Хятад 3 хэл дээр байна гээд. Бидэнд байгаа нь 3 хэл дээр байгаа мөртөө 2 хэл дээрх материал нь тараагдчихсан. 3 дахь хэл дээр байгаа материал ямар юм байгааг бид бас сайн мэдэхгүй. Монгол хэл дээр байгаа материал маань албан ёсны орчуулга гэж байгаа. Ямар хэлнээс орчуулсан нь бас тодорхойгүй. Бид нар бол орчуулгын материал яриад байж байгаа. Цаашдаа бол олон гэрээ хэлэлцээрүүдийн бас суурь болж өгөх байх гэж бодож байгаа. Тэгээд энэ дээрээ цаашид Гадаад яам энэ байдлуудыг анхаарч ажилламаар байна. Өөрөөр хэлэх юм бол Их Хурлын гишүүд энэ гэрээ хэлэлцээр маань Монгол Улсын язгуур эрх ашигтай, Монгол Улсын үндэсний эрх ашигтай яв цав нийцэж байна гэдгийг бүрэн сайн ойлгож ухамсарлаж саналаа өгөх нь бол оновчтой байгаад байгаа юм. Ийм учраас Гадаад яам ч энэ дээр бас үүргээ хүлээж ажиллах ёстой юм.

Уг нь бид өмнө нь хэлэлцэж байхад тэр Батнайрамдал гишүүний яриад байгаа үнэн. Маш олон боомтуудыг бид нар нэр дурдсан шүү дээ. Тэд нар маань алга болчихсон. Энийгээ орхигдуулахгүй байх асуудлыг Аж үйлдвэрийн яам, холбогдох яам анхаарч ажилламаар байна. Замын яам. Тэгээд зөвхөн Гашуунсухайт-Ганцмодны боомтоо холбоод, нүүрс тээвэрлэлт, уурхай өргөжүүлэх ажлаа хийгээд энэ гэрээ цаашаа зогсчихмооргүй байгаа. Тэгээд ер нь бол маш богино хугацаанд хилийг холбочихно гэж байгаа. Хил холбосны дараа тэгээд зэрэгцүүлээд бусад боомтуудын хийх ажлыг сайн анхаарч ажилламаар байгаа юм.

Тэгээд сүүлийн үед Засгийн газар чинь өөрөө санаачлаад энэ төрийн өмчийн аж ахуйн нэгжүүдийн үр ашгийн талаар ярьж байгаа. Төрийн өмчийн байгууллагууд, аж ахуйн нэгжүүд. Тэр “Эрдэнэс Монгол” компани, Эрдэнэс Тавантолгой компаниуд үр ашигтай ажиллах тал дээрээ нэлээн сайн анхаарч ажилламаар байгаа юм. Ямар хүмүүсийг ажилд томилох вэ, ямар хүмүүс нь юу хариуцаж байна, нийт ажилчдын хэдэн хувь нь өрөөнд сууж, цаас хийдэг юм. Тэр цаас нь хэр бодитой юм. Хэдэн хувь нь яг ажил дээрээ, талбай дээр ажиллаж байгаа тэр хүмүүсийнхээ нийгмийн асуудлыг, тэр хүмүүсийнхээ ажиллах бололцоог хэр хангаж байгаа юм. Яг 1 аймагт байгаа тэр Оюутолгой, Тавантолгой гэдэг 2 ордод ажиллаж байгаа компанийг харахад л маш их ялгаа харагдаж байгаа шүү дээ. Нийгмийн асуудал дээр. Эдгээр асуудлуудыг бол маш сайн анхаарч ажиллах шаардлагатай байгаад байгаа юм.

Тэр царигийн асуудал байна. Монголчуудыг 10 гаруй жил талцуулсан, хооронд нь зодолдуулсан, эцсийн бодит байдал дээрээ энэ царигийн асуудал нь

нөгөө л яриад байсан асуудал нь хэвээрээ байж байгаа. Тэгээд энэ хэлэлцээр маань ер нь анх ярьж байсан зүйлүүдээсээ, бид нарын гаргасан асуудлуудаасаа нэлээн ухралттай орж ирж байгаатай санал нэг байгаа. Тэгээд энэ асуудлуудыг Аж үйлдвэрийн яам сайн анхаарч ажилламаар байна.

Өнөөдөр бол та бүхэн Монгол улсад бий болчихсон мухар замыг холбож байгаа, 2 замыг 1 болгож байгаа Тү Ван гэдэг сайдын түүх үлдэж байгаа. Энэ эргээд ямар дүгнэлтэд очих вэ гэдэг чинь өөрөө дахиад дараагийн нэг түүх үлдээж байгаа. Хэдэн жилийн дараа дахиад 1 киноны гол дүр болохгүйн тулд та бүхэн энэ асуудлуудыг сайн анхаарч ажиллах ёстой. Тийм учраас сая гишүүдийн яриад байгаагаар тэр авлигын асуудал, ашиг сонирхлын асуудал, бусад гишүүдийн өмнө нь ярьсан тэр хэлэлцээрийг хийхдээ анхаарах ёстой асуудлуудыг яаж хадгалах вэ, яаж хамгаалах вэ гэдэг дээр энд оролцож байгаа Гадаад яам, Зам, тээврийн яам, Аж үйлдвэр, эрдэс баялгийн яам, бүх яамнууд анхаарах ёстой. Тэр эрчим хүчний асуудал яах юм. Усны асуудал яах юм. Баяжуулах үйлдвэр барьчихсан байсан усны асуудал шийдэгдээгүй л байгаа. Гашуунсухайт боомт усны асуудалгүй л байгаа. Орон нутгийн эрх ашиг нь хаана явж байгаа гээд маш олон асуудлыг сайн анхаарч ажиллаарай гэдгийг энд зориуд тэмдэглэж хэлье.

Р.Сэддорж: Мөнхсоёл гишүүн үг хэлнэ.

Б.Мөнхсоёл: Бүгдийнх нь өдрийн амар амгаланг айлтгая. Тэгээд бас 2 хурлын дунд явж байгаа юм. Өнөөдөр Тамхины хяналтын хуулийн ажлын хэсэг олон улсын шинжтэй форум зохион байгуулж байна. Тэнд оролцоод тэгээд үе үе орж гараад байгаад уучлал хүсье.

Мэдээж манай мундаг гишүүд маань чухал асуудлуудыг асуучихсан байгаа байх. Гашуунсухайт энэ төмөр замын асуудал удаа дараа хэлэлцэгдлээ. Миний хувьд зүгээр сануулж хэлэх гэсэн нэг зүйл юу вэ гэхээр сая Батсүмбэрэл гишүүн хэлж байна. АА гээд. Ажилгүйдэл, авлига гээд. Тэр дээр нэмэх нь алдагдсан боломжийн өртөг гэж том асуудал байгаад байна шүү дээ. Энэ олон жил, 16 жил яригдсан шийдэгдээгүй. Яагаад. Яагаад гэвэл нөгөө авлига, нөгөө улс төр, нөгөө ил тод биш байдал, нөгөө муу засаглал энэ бүхэн холбоотой.

Ээлжит бус чуулган эхлэхэд би хэлж байсан. Монгол Улсад итгэлцэл гэж юм байхгүй болчихсон. Судалгаагаар асуухад би ойр дотнын хэдэн хамаатан, ганц хоёрхон найз нөхдөдөө л итгэдэг болчихсон гэхихсэн байхгүй юу. Тэгэхээр өнөөдрийн бид нарын улс төрд орсон энэ шинэ гишүүдийн хувьд энэ том том төслүүдийг дэмжих асар их хүсэл байгаа. Эдийн засаг хөгжөөсэй, тэлээсэй. Хүмүүс маань ажлын байртай болоод хэн нэгнээс царайчилсан, гуйсан, ажил гуйсан тийм халамж гуйсан биш, өөрийн гэсэн ажилтай, цалинтай, орлоготой болж, амьдралаа өөрсдөө авч явдаг болоосой гэдэг үүднээс явж байгаа. Тэр утгаараа том том төслүүд яваасай гэж чин сэтгэлээсээ хүсэж байгаа. Тэгэхээр нийгэмдээ мэдээллийг сайн өг. Яагаад яагаад гэдэгт хариул. Зөвхөн энэ дотор байгаа гишүүд нэг хэсэг нь зөв юм яриад, нэг хэсэг нь попрод байдаг бол энэ асуудал дахиад 2028 оны сонгууль эхлэхэд дахиад нэг ийм хөөрхөн попролт явна гэдгийг бүгд мэдэж байна. Тэгэхээр энэ дээр сайн анхаараарай. Дэмжсэн тохиолдолд маш сайн засаглалтай яваарай. Хувийн эрх ашиг, намын эрх ашиг, фракц, мөнгө хөрөнгийн төлөө битгий яваасай гэж гуйж байна. Энэ гишүүдийн дэмжлэгийг битгий үрэн таран хийгээсэй гэж хүсэж байна.

Тэгээд нэмж хэлэхэд зарим нэг гишүүд маань заримдаа поп байна. Бусад гишүүдийн эрхэд халдаж байна. Тэрийг болохгүй. Бүх гишүүн халдашгүй эрхтэй. Үг, дуу хоолойгоо зөв ч бай, буруу ч бай илэрхийлэх эрхтэйгээр энд сонгогдсон байгаа шүү. Баярлалаа.

Р.Сэддорж: Ингээд манай Эдийн засгийн байнгын хороо бараг 2 дахь удаагаа энэ асуудлыг хэлэлцэж байна. Ингээд манай Байнгын хороогоор ороод бид нар бол дэмжиж байгаа. Олонх нь дэмжээд эхний хуралдаанаар бол дэмжээд явж байгаа. Энэ бол 2 мухар төмөр замыг хооронд нь холбож, эдийн засгийн эргэлтэд оруулж, төмөр зам тавьсны үр дүнг үзэх гэж байгаа л ийм ажил. Тэгээд энэ 250км төмөр замыг Монголын ард түмний хөрөнгөөр барьсан. Тавантолгойгоос Гашуунсухайт хүртэл. Тэр төмөр зам асар их хөрөнгөөр барьсан. Тэр нүүрсийг олборлох гэж Эрдэнэс Тавантолгой компани асар олон хөрс хуулсан. Асар ихнүүрс борлуулж, байгаль орчин Цогтцэций сумын тэр тоос шороо гээд асар их үнэ цэнтэй ийм төмөр зам. Энэ төмөр замыг холбоё гэдэг дээр бол манай Байнгын хороо санал нэгтэй байгаа. Тэгээд гишүүдийн саналыг та бүхэн маань энэ гэрээ байгуулахдаа тусгаад, чухал чухал санаануудыг хэлж байгаа. Тэгээд тусгаж ажиллаарай гэдгийг хэлье.

Тэгээд энэ ер нь бол Тавантолгойн орд бол байршил сайтай учраас борлуулалт сайтай ийм орд. Хамгийн ойрхон байгаа. Ийм учраас энэ жилийн хувьд 800-аад сая тонн нүүрс өөрийнхөө дотоодын уурхайнуудаасаа олборлож байгаа ийм компанитай та бүхэн Засгийн газар хооронд гэрээ хийж байгаа. 800 сая тонн. Тэгээд манай 20 сая тонн ирээдүйд гарах юм байна. Тэгээд 800 саяын 20 сая бол 2,5 хувь нь байх. Тэгэхээр энэ дээр бол хэлэлцээрээ хийгээд явчихсан нь дээр байх. Тэгээд хамгийн гол нь бол гишүүдийн хэлж байгаа үнийг маш өндөр байлгах, үнийг боломжит хамгийн өндөр байлгахгаар та бүхэн энэ хэлэлцээрээ анхаарч хийх хэрэгтэй. Уурхайн олборлолтын хувьд бол мэдээж Монгол Улсын төрийн болон орон нутгийн өмчийн хөрөнгөөр бараа, ажил, үйлчилгээ худалдан авах хуулиар зохицуулагдах байх. Тэгээд энэ дээр та бүхэн маань гишүүдийн энэ хэлж байгаа саналыг сайн тусгаж ажиллаарай.

Дээрээс нь тэр хил холболтын үйл ажиллагаанд Монголын болон дотоодын орон нутгийн аж ахуйн нэгж, иргэдийг ажлын байраар хангах, тэнд нэмүү өртгийг үлдээх, мэдээж хил давуулж газар шорооны ажлуудын юу орж ирэхгүй байлгүй. Түгээмэл тархацтай ашигт малтмал. Тэгэхээр дотоодоосоо авч таарна. Гэх мэтээр орон нутгийг, ард иргэдийг сайн дэмжээрэй. Эдийн засаг бас яг тэр хавьд бол маш хэцүү байгаа. Маш олон хүн, 30 мянган машин тэнд зогсож байгаа. Өдөрт мянган машин, мянга гаруй машин хилээр гарч байгаа юм байна. Тэгэхээр үлдсэн 29 мянган машин, түүний ард байгаа маш олон иргэдийн амьжиргааг дээшлүүлэх тал дээр та бүхэн маань бас дэмжиж ажиллаарай гэдгийг хэлье.

Р.Сэддорж: Одоо Мандхай гишүүн үг хэлнэ.

М.Мандхай: Энэ өдрийн мэнд хүргэе. Бид нар манай байнгын хороо бас Гашуунсухайт-Ганц модын үйл ажиллагаатай очиж биечлэн танилцсан. Тэгээд яах вэ, манайд бол угаасаа уул уурхайгаа түшиж эдийн засаг бол хөгжих нь бол ойлгомжтой. Гэхдээ нэг ийм асуудал байгаад байгаа юм. Бид нар бизнесээ босгочхоод, яаж үр ашигтай, бүтээмжтэй хурдан хугацаанд ашиг олох вэ гэдэг дээр анхаараад тээвэр логистикийн асуудлууд дээр ач холбогдол өгч ажилладаг. Гэхдээ бас нэг чухал юм нь энийг хэн ажиллуулж байгаа юм. Үүний цаана эргэн

тойрон, орчинд нь ямар асуудлууд нөлөөллийн асуудлууд хөндөгдөж байгаа вэ гэдэг дээр ерөөсөө ач холбогдол өгөхгүй явж ирдэг. Энэ дээр бол бүгдээрээ бас хүлээн зөвшөөрөх нь зүйтэй байх.

Одоо ялангуяа тэнд ажиллаж байгаа ажилчид болон эргэн тойронд амьдарч байгаа иргэдийн асуудал гэхээр яг үндсэндээ бол нийт мал нь уушгины өвчлөлтэй, иргэд нь өөрөө харшилтай ийм хүнд нөхцөл байдалд нөгөө Үндсэн хуулиар хамгаалагдсан хүний эрүүл орчинд амьдрах эрх, нөгөө үзэл бодлоо илэрхийлж, асуудлуудаа шийдвэрлүүлэх, аюулгүй орчинд ажиллаж, амьдрах эрхийн асуудлууд бол үнэхээр тэнд зөрчигдчихсэн байна. Энийг Тээвэрчдийн холбоо ч гэсэн удаа дараа энэ асуудлыг хэлээд, өнөөдрийг хүртэл ямар ч бүтээн байгуулалт тэнд хийгдсэн юм байхгүй яваад байгаа юм. Бид нар яаж нүүрсээ л хурдан гаргах вэ гэдэг асуудал ярьж байгаа боловч тэнд амьдарч байгаа нийгмийн асуудлуудыг бүрэн бүтэн хаясан байгаад байгаа. Тэнд тээвэрчдийн явж байгаа нөхцөл байдлыг харахад бол маш өрөвдмөөр байлаа шүү дээ. Тэгээд Гашуунсухайт боомтын ерөнхий төлөвлөгөө гэж юм 15 жилийн өмнө хийгдсэн юм байна. Одоо энэ Нью Урбанизм гэдэг компани хийх гээд явж байгаа юм байна. Энэ дээр бол бүр онцгой ач холбогдол өгөөч сайд аа. Энэ нийгмийн асуудлуудыг бид нар анхаарахгүй бол энд ажиллах залуу хүн ажиллах хүчгүй болох нь. Биегүй баахан залуучуудаар дүүрлээ. Тийм учраас бид нар энэ чингэлэг тээврийн терминалыг түшсэн амрах байр хэрэгтэй байна. Хоолны газар, усанд орох газар, ядаж хааяа нэг ороод амарчихдаг ийм орчин үүсгэх хэрэгтэй байна. Цаашдаа энэ чинь ганцхан нүүрс гэхгүй энгийн зорчигчдын терминал ч гэсэн байгуулагдах нь тодорхой шүү дээ.

Тэгэхээр энэ дээр онцгой анхаараад, энэ нийгмийн асуудлуудыг давхар ингээд шийдвэрлээд яваач ээ гэсэн тэгээд ерөнхий төлөвлөгөө байгаа бол энэ төлөвлөгөөтэй нь танилцмаар байна. Эдийн засгийн байнгын хороо дээр яг энэ ерөнхий төлөвлөгөөтэй нь бас бид нар танилцахыг хүсэж байна. Өөрсдийнхөө бас саналыг ч гэсэн оруулмаар байна. Тэгээд энэ дээр ингэж анхаарч ажиллаарай гэж хэлмээр байна.

Р.Сэддорж: Засгийн газраас томоохон төслүүд хамтарсан Засгийн газраас орж ирж, манай Байнгын хороо болон Улсын Их Хурлаар олонхын дэмжлэг авч, монголчуудын маань олон жил хүсэн хүлээж байсан жишээ нь нефтийн үйлдвэр байна. Нефтийн үйлдвэрийг бол ашиглалтад орохыг л хүлээж байгаа. Энэ бол хэр зөв зүйтэй, зөв замаар, шударга явж байгаа гэдгийг бол энэ хяналтын байгууллагууд энэ дээр дүгнэлтээ гаргана. Тэгэхээр түүнтэй адилхан бас энэ монголчуудын хүсэн хүлээж байсан 1992 онд ашиглалтад орсон 2 улсын боомт, тэгээд 2004 онд экспорт эхэлсэн, 2009 онд авто зам, засмал замаар холбогдсон. Тэгээд 2025 оноос төмөр зам нь хоорондоо холбогдох ийм ажлууд хийгдэж байгаа. Тэгээд дараагийн бас та бүгдийн оруулж ирэх төсөл бол энэ усны төсөл байх болтугай гэж хүсэж, мөрөөдөж байгаа. Тэгээд монголчуудад, говийн ард түмэнд гүний усыг нь үр хүүхдэд нь үлдээе. Байгаа гадаргын усаа зөв зүйтэй ашиглаад ингээд бас хөрш орнуудтай хийж байгаа хэлэлцээрт та бүхэн одоо яг энэ удаагийн хэлэлцээр бол хөрш улстай хийж байгаа, төрийн өмчийн компанитай хийж байгаа. Тэгэхээр энэ Хэрлэн-Тооно төслийг та бүхэн маань бас хэдийгээр шууд холбогдолгүй ч гэсэн энэ төлбөрийг төлөх гэж байгаа Эрдэнэс Тавантолгой компанитай холбоотой учраас Эрдэнэс Тавантолгой компанийн тэр загийн усны хоолой, цаанаас нь энэ гадаргын усыг холбох тал дээр та бүхэн маань дараагийн энэ том төсөл болгож оруулж ирэх байх. Ерөнхий сайд бас энэ дээр санал нэгтэй

гадаад айлчлал дээрээ гадаадын одоо хөрөнгө оруулагчдад энэ саналуудыг тавьж байгаад бол бид нар харсан. Баяртай байгаа.

Ингээд гишүүд үг хэлж дууслаа. Санал хураалт явуулна. Гишүүд санал хураалтад идэвхтэй оролцохыг хүсье.

“Гашуунсухайт-Ганцмод боомтын хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Тавантолгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийг зөвшилцөхийг дэмжье гэсэн томъёоллоор санал хураалт явуулъя. Санал хураалт. 78,6 хувийн саналаар дэмжигдлээ. Санал хураалт явуулж дууслаа.

“Гашуунсухайт-Ганцмод хил дамнасан төмөр зам, нүүрсний худалдаа, Таван толгойн нүүрсний уурхайн хүчин чадлыг нэмэгдүүлэх хамтын ажиллагааны тухай Монгол Улсын Засгийн газар болон Бүгд Найрамдах Хятад Ард Улсын Засгийн газар хоорондын хэлэлцээр”-ийн төслийн талаарх Эдийн засгийн байнгын хорооны санал, дүгнэлтийг Аюулгүй байдал, гадаад бодлогын байнгын хороонд Улсын Их Хурлын гишүүн Батсүмбэрэл уншиж танилцуулна.

Хэлэлцээрийн төслийг хэлэлцэж дууслаа. Эдийн засгийн байнгын хорооны эрхэм гишүүддээ баярлалаа.

Улс орныхоо өмнө тулгамдаад байгаа томоохон төслийг Байнгын хороогоороо өндөр хувьтай дэмжиж, явуулсанд их баярлалаа. Тэгээд энэ ажлын хэсгийнхэн, яам, Туваан сайд гишүүдийн санаа бодлыг маш сайн тусгаж, Монгол Улсынхаа төлөө маш хурдтай ашиглалтад оруулахын төлөө хичээж ажиллаарай.

Ингээд хуралдаанд идэвхтэй оролцсон гишүүд ажлын хэсгийнхэндээ баярлалаа юу юу гишүүд Үндсэн хууль танхим руу орчихъё энд байгаа. Аюулгүй байдал гадаад бодлогын байнгын хороо.

12.53 цаг.

*ДУУНЫ БИЧЛЭГЭЭС ХУРАЛДААНЫ ДЭЛГЭРЭНГҮЙ
ТЭМДЭГЛЭЛ БУУЛГАЖ, ХЯНАСАН:
ШИНЖЭЭЧ*

Э.СУВД-ЭРДЭНЭ